

МОНГОЛ УЛС

ШҮҮХИЙН ИНДЕКС



2021

МОНГОЛ УЛС ШҮҮХИЙН ИНДЕКС 2021



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



ОЮУНЫ
ИННОВАЦИ
ТББ

ОЮУНЫ
ИННОВАЦИ

ННА 67
ДАА 340
М-692

МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ИНДЕКС 2021
judindex.forum.mn

Санаачлагч
НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

Гүйцэтгэгч
ОЮУНЫ-ИННОВАЦИ ТББ

Судалгааны баг
Т. Алтангэрэл, “Оюуны-Инноваци” ТББ-ын Удирдах зөвлөлийн дарга
П. Баттулга, “Оюуны-Инноваци” ТББ-ын Судлаач, хуульч
Б. Төрболд, “Оюуны-Инноваци” ТББ-ын Судлаач, хуульч
Д. Аюуш, Социологич
Г. Гэсэр, Дата аналит
С. Цэрэндолгор, Хуульч

Хянан тохиолдуулсан
П.Бадамрагчаа, ННФ-ын Эрх зүйн хөтөлбөрийн менежер

Өгөгдлийн дүрслэл ба тайлангийн дизайн
ТУНГААХУЙ ӨГӨГДЛИЙН УРЛАН

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ
Жамьян гүний гудамж
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар - 14240
976-76113207
osf@forum.mn
<http://www.forum.mn>

ISBN 978-9919-9926-1-3
© Нээлттэй Нийгэм Форум, 2022

ГАРЧИГ

Өмнөх үг	4
Товчилсон үг	6
Хүснэгт, зургийн жагсаалт	7

ШҮҮХИЙН ИНДЕКС 2021 8

1.1 Танилцуулга	10
1.2 Шүүхийн индексийн хөтөч	16
1.3 Шүүхийн индекс 2021	18

ШҮҮХИЙН ИНДЕКС ТООЦОХ АРГА ЗҮЙ 20

2.1 Зорилго	22
2.2 Шүүхийн индексийн шалгуур үзүүлэлт	22
2.3 Өгөгдлийн эх сурвалж	30
2.4 Шүүхийн индекс тооцох арга зүй	32

ШҮҮХИЙН ИНДЕКСИЙН ҮНДСЭН ХЭМЖИГДЭХҮҮН 40

3.1 Шүүхийн эрх хэмжээ, бие даасан байдал	45
3.2 Шүүхийн нээлттэй, ил тод байдал	48
3.3 Шүүхэд итгэх олон нийтийн итгэл	50
3.4 Шүүхийн дэд бүтэц, нөөц	52
3.5 Шүүгчийн ёс зүй ба хариуцлага	54
3.6 Шүүхийн үр ашигтай үйл ажиллагаа	56

ШҮҮХИЙН ИНДЕКСИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ 58

4.1 Олон нийтийн санал асуулгын дүн шинжилгээ	62
4.2 Мэргэжилтнүүдийн санал асуулгын дүн шинжилгээ	65
4.3 Олон нийтийн санал асуулга ба мэргэжилтнүүдийн санал асуулгын харьцуулалт	67
4.4 Захиргааны мэдээлэлд суурилсан дүн шинжилгээ	72

ХАВСРАЛТ 78

1. Шүүхийн индексийн үр дүнгийн нэгдсэн хүснэгт	78
2. Олон нийтийн санал асуулгын үнэлгээ	85
3. Мэргэжилтнүүдийн санал асуулгын үнэлгээ	87
4. Шүүгчийн ажлын ачааллын дэлгэрэнгүй өгөгдөл	90
5. Мэргэжилтнүүдийн санал асуулгын хуудас	98
6. Олон нийтийн санал асуулгын хуудас	104

ӨМНӨХ ҮГ

Нээлттэй Нийгэм Форум нь чанартай мэдээлэл, судалгаанд үндэслэсэн, үр нөлөөтэй, олон талын оролцоог хангасан өргөн хүрээний бодлогын хэлэлцүүлэг зохион байгуулах, оролцогч талуудын чадавхыг дээшлүүлэх зорилгоор 2004 оноос хойш үйл ажиллагаа явуулж буй үндэсний төрийн бус байгууллага юм. Эрх зүйн шинэтгэлийг дэмжих чиглэлээр төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэдийн эрх зүйн чадамжийг дээшлүүлэх тогтолцоог төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулж ирсэн бөгөөд 2008 оноос шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх, эрүүгийн эрх зүйн шинэтгэлийг дэмжих стратегийн зорилт тавин ажиллаж байна.

Өнгөрсөн хугацаанд шүүх эрх мэдлийн хүрээнд хөндлөнгийн судалгаа шинжилгээний чадавхыг бий болгох, шүүхийн шинэтгэлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх явцад талуудын мэдээлэлтэй, бодит оролцоог хангах, судалгаанд суурилсан бодлогын нөлөөлөл хийх, шаардлагатай техникийн туслалцаа, дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлж ирлээ.

Сүүлийн 10 жилд өрнөж буй шүүх эрх мэдлийн шинэтгэлийн үр нөлөө сул байгаа нь Үндсэн хуулийн хязгаарлалт, шүүхийн томилгооны эрх мэдлийн төвлөрөл, төсвийн дэмжлэг хомс, улс төрийн нөлөөнд орох өндөр эрсдэл, хариуцлагын сул тогтолцоо зэрэг олон хүчин зүйлээс улбаатай. Эдгээр асуудлыг шийдэх чиглэлээр хууль тогтоомжийн өөрчлөлт хийгдсэн ч хэрэгжүүлэх шатанд олон саад бэрхшээл тулгарч, шинэтгэлийн анхдагч үзэл баримтлал алдагдах эрсдэл их байна. Иймд шинэтгэлийн үйл явц, үр дүнд шинжилгээ хийж, бодит, хэмжиж болохуйц үнэлгээ өгөх зорилгоор Шүүхийн индекс судалгааг **Нээлттэй Нийгэм Форум** санаачлан эрх зүйн судалгааны **"Оюуны -Инноваци" ТББ**-тай хамтран хийж гүйцэтгэлээ.

Шүүхийн талаар зургаан үндсэн хэмжигдэхүүнээр олон нийт, мэргэжилтнүүдийн санаа бодол болон статистик мэдээлэлд тулгуурлан үнэлгээг тоон утгаар илэрхийлж, он цагийн давтамжтай харуулах индексийн судалгааг олон улсын туршлага, төсөөтэй үнэлгээний индексийн арга зүйг харьцуулан судалж, салбарын тэргүүлэх шинжээч, мэргэжилтнүүдийн санал шүүмжийг тусгах замаар боловсруулсан болно.

Шүүхийн индексийн хамрах хүрээ, арга зүйг боловсруулахад үнэтэй санал шүүмж харамгүй өгсөн зөвлөлдөх багийн гишүүн УДШ-ийн шүүгч Б.Батцэрэн, Ц.Цогт нар, ШЕЗ-ийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга асан, хууль зүйн доктор Т.Мэндсайхан, ШЕЗ-ийн Тамгын газрын дарга асан, судлаач С.Билгүүн, хууль зүйн салбарын эрдэмтдийн төлөөлөл болох доктор О.Мөнхсайхан, доктор А.Бямбажаргал, доктор Б.Гүнбилэг нарт болон хуульч, өмгөөлөгчдийн төлөөлөл болох Н.Баасанжав, Х.Номингэрэл, Ж.Хунан, П.Баттулга нарт гүн талархал илэрхийлье.

Шүүхийн салбарын бодлогын судалгаа, нөлөөллийн ажилд бидэнтэй хамтран ажиллаж ирсэн хараат бус эрх зүйн судалгааны байгууллага болох "Оюуны-Инноваци" ТББ-ын Удирдах зөвлөлийн дарга Т.Алтангэрэл, тус байгууллагын судлаач П.Баттулга, Б.Төрболд, социологич Д.Аюуш, дата аналит Г.Гэсэр, судлаач С.Цэрэндолгор нар индексийн мэдээлэл цуглуулж, нэгтгэн боловсруулах ажлыг хариуцан индексийн судалгааны үндсэн багт ажиллалаа. Шинэ тутам судалгааны арга зүйг нэвтрүүлж, индексийн судалгааг амжилттай хэрэгжүүлсэн судалгааны багийн гишүүдэд талархал илэрхийлж цаашдынх нь судалгаа шинжилгээний ажил үйлсэд нь амжилт хүсье.

Монголын судалгааны тэргүүлэх байгууллагуудын нэг болох "Эм Эм Си Жи" ХХК-ийн Судалгаа, хөгжил хариуцсан захирал Ч.Даваасүрэн ахлагчтай судалгааны баг шүүхийн талаар олон нийтийн санал бодлын судалгааг гүйцэтгэсэн бол Э.Тунгалаг захиралтай "Тунгаахуй өгөгдлийн урлан"-ийн хамт олон индексийн өгөгдлийн дүрслэл, тайлангийн дизайныг хариуцан ажилласан бөгөөд бидний ажилд үнэтэй хувь нэмэр оруулсанд нэн талархалтай байна.

Шүүхийн индекс төсөл нь Монгол Улсын шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж, шүүхийн салбарын бодлого боловсруулагчид, хэрэгжүүлэгчдийн үйл хэрэгт бодитой дэмжлэг болно хэмээн гүнээ найдаж байна.

Тайланг цахим хэлбэрээр judindex.forum.mn хаягаар орж, нээлттэй өгөгдөл хэлбэрээр танилцах боломжтой. Шүүхийн индексийн арга зүй, тайланг цаашид боловсронгуй болгох аливаа ажил хэрэгч шүүмж, саналыг хүлээн авч хамтран ажиллахдаа таатай байх болно.

П. Эрдэнэжаргал

Гүйцэтгэх захирал

Нээлттэй Нийгэм Форум

ТОВЧИЛСОН ҮГ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ЗМ	Захиргааны мэдээлэл
МСА	Мэргэжилтнүүдийн санал асуулга
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОНСА	Олон нийтийн санал асуулга
ТББ	Төрийн бус байгууллага
УБ	Улаанбаатар
УДШ	Улсын дээд шүүх
УИХ	Улсын Их Хурал
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Монгол Улсын шүүхийн тогтолцоо	11
Зураг 2.	Шүүхийн индексийн шалгуур үзүүлэлт	16
Хүснэгт 1.	Шүүхийн индексийн үндсэн хэмжигдэхүүн, дэд хэмжигдэхүүн, шалгуур үзүүлэлтийн тоо	22
Хүснэгт 2.	Шүүхийн индексийн шалгуур үзүүлэлтийн тоо, өгөгдлийн эх сурвалжаар	30
Хүснэгт 3.	Үндсэн хэмжигдэхүүний индекст эзлэх жин	33
Хүснэгт 4.	Судалгааны хариултанд оноо өгсөн аргачлалын жишээ	34
Хүснэгт 5.	Аргачлал 1. Захиргааны мэдээлэлд оноо өгсөн аргачлалын жишээ	36
Хүснэгт 6.	Аргачлал 2. Захиргааны мэдээлэлд оноо өгсөн аргачлалын жишээ	37
Хүснэгт 7.	Аргачлал 3. Захиргааны мэдээлэлд оноо өгсөн аргачлалын жишээ	38
Хүснэгт 8.	“2.8.1 Шүүхийн төсвийн зарцуулалтын тайланг тогтмол гаргаж, олон нийтэд мэдээлдэг.” шалгуур үзүүлэлтийн үнэлгээ	72
Хүснэгт 9.	“5.6.1 Шүүгчийн эсрэг гаргасан гомдол, түүний төрөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг нийтэд бүрэн, ил тод мэдээлдэг.” шалгуур үзүүлэлтийн үнэлгээ	72
Хүснэгт 10.	“5.6.1 Шүүгчийн эсрэг гаргасан гомдол, түүний төрөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг нийтэд бүрэн, ил тод мэдээлдэг.” шалгуур үзүүлэлтийн үнэлгээ	74
Хүснэгт 11.	“6.1 Шийдвэрлэгдээгүй хэргийн тоо” дэд хэмжигдэхүүний үнэлгээ	74
Хүснэгт 12.	“6.2 Хэрэг шийдвэрлэлтийн хувь” дэд хэмжигдэхүүний үнэлгээ	75
Хүснэгт 13.	“6.3 Шүүгчийн ажлын ачаалал” дэд хэмжигдэхүүний үнэлгээ	76
Хүснэгт 14.	“6.4 Шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал” дэд хэмжигдэхүүний үнэлгээ	77
Хүснэгт 15.	“6.7.3-6.7.5 Эрүүгийн, иргэний, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлт сайн байдаг.” шалгуур үзүүлэлтийн үнэлгээ	77

1.1 ТАНИЛЦУУЛГА

1.2 ШҮҮХИЙН ИНДЕКСИЙН ХӨТӨЧ

1.3 ШҮҮХИЙН ИНДЕКС 2021

1



ШҮҮХИЙН
ИНДЕКС 2021

1.1 ТАНИЛЦУУЛГА

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХ

Ардчилалд шилжихийн өмнөх үеэс өгүүлбэл 1960 оны Үндсэн хуульд зааснаар шүүх бүх үйл ажиллагаандаа өнгөндөө ардчилсан зарчмууд баримталж байсан мэт боловч захиргаадлын зэвсэг болж байсан ба шүүхүүд сонгуулиар зохих хурал ба иргэдээс байгуулагдах

зарчимтай байв.¹ Харин 1992 оны ардчилсан, шинэ Үндсэн хуулиар шүүхийн өмнөх тогтолцоонд эрс шинэчлэл хийгдэж, шүүх эрх мэдлийг “төрийн эрх мэдлийг хуваарилах” онол, зарчмын үүднээс тодорхойлсон юм.

Үндсэн хуулийн Гуравдугаар бүлэг Монгол Улсын төрийн байгуулал гэсэн хэсгийн “Дөрөв. Шүүх эрх мэдэл” гэсэн хэсэгт тусгайлан оруулж, Дөчин долдугаар зүйлийн 1-д “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ”, 2-т “Ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно”, Дөчин есдүгээр зүйлийн 2-т “Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй” гэж зааснаас харж болно.


Шүүхийг Монгол Улсын Үндсэн хууль болон шүүхийн тухай холбогдох хуульд заасан журмын дагуу хуулиар байгуулж, өөрчлөн байгуулж, татан буулгана. Одоогийн байдлаар Монгол Улсад хяналтын шатны 1 шүүх, давж

заалдах шатны 26 шүүх, анхан шатны 90 шүүх, нийт 117 шүүх ажиллаж байна. Үүнийг бүдүүвч зургаар Зураг 1-д харуулав.²

¹ Ж.Амарсанаа нар “Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэл (сүүлийн 20 жилийн тойм)” Нээлттэй Нийгэм Форум. УБ., 2010, 10 дахь тал (дам ишлэв).

² Бүдүүвч зургийг Цагаанбаяр нар “Шүүхийн тогтолцоо: Тойргийн болон дагнасан шүүх (бодлогын судалгаа)” Нээлттэй Нийгэм Форум. УБ., 2021, 35 дахь талаас авав.

Зураг 1. Монгол Улсын шүүхийн тогтолцоо



2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн байдлаар Монгол Улсын бүх шатны 117 шүүхэд нийт 512 шүүгч ажиллаж байгаагаас анхан шатны шүүхэд 389, давж заалдах шатны шүүхэд 101, хяналтын шатны шүүхэд 22 шүүгч ажиллаж байна.³

Үндсэн хууль болон шүүхийн тухай хууль тогтоомжийн дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, хуульчдаас шүүгчийг шилж олох, шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс хэрэг, маргааныг шийдвэрлэхэд мэдээлэл, судалгаа, санхүү, аж ахуй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэн, ажиллах нөхцөлөөр хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.⁴ Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүгч болон шүүгч бус гишүүний тэнцүү төлөөлөл бүхий 10 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүхээс нэг, давж заалдах болон анхан шатны шүүхээс тус бүр хоёр шүүгчийг Нийт шүүгчийн чуулганаас нууц санал

хураалтаар сонгож, шүүгч бус 5 гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн нь 4 жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллана.

Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл оногдуулах чиг үүргийг бие даасан байгууллага болох Шүүхийн сахилгын хороо гүйцэтгэнэ. Шүүхийн сахилгын хороо нь шүүгч 4, шүүгч бус 5, нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүхээс нэг, давж заалдах шатны шүүхээс хоёр, анхан шатны шүүхээс нэг шүүгчийг Нийт шүүгчийн чуулганаас нууц санал хураалтаар сонгож, шүүгч бус 5 гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно. Сахилгын хорооны гишүүн нь 6 жилийн хугацаатай зөвхөн нэг удаа ажиллана.

³ "Монгол Улсын Шүүхийн тайлан 2021. УБ., (2022), 42 дахь тал.

⁴ Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1-д "Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Ерөнхий зөвлөл нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зорилго бүхий шүүхийн захиргааны төв байгууллага мөн" гэж заажээ.

ШҮҮХИЙН ИНДЕКС ТООЦОХ ҮНДЭСЛЭЛ БА ТОВЧ ТОЙМ

Монгол Улсын 1992 оны Үндсэн хууль, 1993 оны Шүүхийн тухай хуулиас эхэлсэн шүүхийн шинэтгэл өнгөрсөн 30 жилийн хугацаанд ахиц дэвшил, ухралт доройтлын аль алиныг туулж өнөөдрийн түвшинд хүрээд байна. Ардчилсан нийгэм, зах зээлийн эдийн засагт үүссэн шинэ харилцааг зохицуулах хуулиудыг хэрэгжүүлэх нийгмийн ухамсар төлөвшлийг бий болгох ажил ч үргэлжилсээр байна. 2002 онд Дэлхийн банк, АНУ-ын Хөгжлийн агентлаг, Германы техникийн хамтын ажиллагааны байгууллага зэрэг томоохон хандивлагчдын техникийн туслалцаатайгаар Монгол Улсын шүүхийн тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль шинэчлэн батлагдсан нь шүүх эрх мэдлийн хүрээний шинэтгэлд чухал алхам болов. Гэвч нийгэм хурдацтай хувьсан өөрчлөгдөхийн хэрээр иргэд шүүхэд хандах, эрх ашгаа хамгаалах эрмэлзэл, хэрэгцээ шаардлага өдөр ирэх бүр нэмэгдэж, хуулийн зохицуулалт шинэчлэгдэх хэрэгтэйг илэрхийлэх боллоо.

Нээлттэй Нийгэм Форум 2008 онд шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх хөтөлбөрөө эхлүүлж, салбарын анхны хараат бус, хөндлөнгийн үнэлгээ⁵ хийж, шүүхэд тулгамдаж буй асуудлыг илрүүлэн оношлох оролдлого хийсэн нь 2012 оны шүүхийн шинэтгэлийн үйл явцад зохих хувь нэмрээ оруулсан билээ. Энэхүү шинэтгэлээр шүүхийг нээлттэй, ил тод болгох чиглэлд бодитой ахиц дэвшил гарч, бие даасан шүүхийн захиргааг бий болгон, шүүхийг тойргийн журмаар зохион байгуулж, шүүхийн иргэдийн төлөөлөгч, тахар зэрэг чухал институтыг бий болгон тусгайлан хуулиар зохицуулах болсон нь энэхүү шинэтгэлийн онцлог байлаа.

Улмаар 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт, түүний мөрөөр 2021 онд баталсан Монгол Улсын шүүхийн тухай хууль нь шүүхийн шинэтгэлд томоохон алхам боллоо. Өмнөх шинэтгэлийн адил олон нийт, хуульчдын дунд нэг талаас ихээхэн хүлээлт, нөгөө талаас багагүй шүүмж дагуулсан энэхүү хуулийн хэрэгжилт 2022 оноос л эхэлж байна.

Нээлттэй Нийгэм Форум өнгөрсөн хугацаанд шүүхийн салбарт хэрэгжүүлсэн судалгаа шинжилгээний туршлагад үндэслэн шүүхийн шинэтгэлийн үйл явцад тогтмол, бодитой үнэлгээ өгөх, ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох зорилгоор Монгол Улсын шүүхийн индексийг хоёр жил тутамд гаргаж шүүхийн салбарын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцад бодитой хувь нэмэр оруулахыг зорьж байна. Монгол Улс Дэлхийн шударга ёсны төслийн Эрх зүйт ёсны индексэд 2015 оноос, Дэлхийн эдийн засгийн форумын Өрсөлдөх чадварын индексэд 2007 оноос эхлэн оролцож, манай шударга ёсны салбар дэлхийн улсуудтай харьцуулахад ямар түвшинд байгаа талаар мэдээлэл авч ирлээ. Эдгээр олон улсын индекс нь арга зүйн хувьд эрх зүйн тогтолцоо, хөгжлийн түвшин харилцан адилгүй олон улсыг харьцуулах боломжтой байх үүднээс бүгдэд хамаарах маш ерөнхий асуумжаар, цөөн эх сурвалжид үндэслэн үнэлдэг тул хууль зүйн салбараас тухайлан шүүхийн салбарын тулгамдаж байгаа тодорхой асуудлыг нарийвчлан харахад хүндрэлтэй байдаг.

Монгол Улсын шүүхийн индекс нь тухайлан шүүхийн салбарт өрнөж буй шинэтгэлийн үр нөлөөг хараат бусаар үнэлж, аливаа ухралтаас сэргийлэх, хэрэгжилтийн шатанд эрчимжүүлэх шаардлагатай асуудлыг тодорхойлох, олон улстай харьцуулах гэхээс илүү гарч буй өөрчлөлтийг хоёр жил тутамд хэмжих

⁵ Брент Т. Уайт, Монгол Улсын шүүхийн шинэтгэлийн өнөөгийн байдалд хийсэн судалгааны тайлан, Нээлттэй Нийгэм Форум, УБ., 2009.

боломжтой болох юм. Монгол Улсын шүүхийн тухай хууль шинэчлэн батлагдсан 2021 онд анхдагч судалгааг хийж байгаа нь цаашид энэхүү хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг индексээр дамжуулан үнэлэх ач холбогдолтой.

Дүгнэж хэлбэл, шүүхийн индекс нь (1) шүүхийн үйл ажиллагааны төлөв байдлыг олон талаас бодитойгоор үнэлэх; (2) шалгуур үзүүлэлтийн оноонд үндэслэн шүүхийн тулгамдсан асуудал, хүндрэл, бэрхшээлийг тодорхойлох; (3) төлөв байдал, тулгамдсан асуудлын үндсэн дээр шүүхийн хүрээнд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, чиг хандлагыг тодорхойлоход чухал хэрэгсэл болно гэж үзэж байна.

Шүүхийн үндэсний индексийн хэмжигдэхүүн, шалгуур үзүүлэлт зэргийг боловсруулахдаа олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дараах индексүүдийг судалж үзлээ. Үүнд:

- Америкийн Барын холбооны Шүүхийн шинэтгэлийн индекс (American Judicial Reform Index)⁶,
- Дэлхийн шударга ёсны төслийн Эрх зүйт ёсны индекс (World Justice Project: Rule of Law Index)⁷,
- Транспаренси Интернэшнлийн Авлигын төсөөллийн индекс (Transparency International: Corruption Perception Index)⁸,
- Дэлхийн эдийн засгийн форумын Өрсөлдөх чадварын индекс (World Economic Forum: Global Competitiveness index)⁹,
- АНУ-ын Шударга ёсны хүртээмжийн үндэсний төвийн Шударга ёсны индекс (National Center for Access to Justice: Justice Index)¹⁰,

- Дэлхийн эрх чөлөөний тайлан (Freedom House: Freedom in the World)¹¹,
- АНУ-ын Хөгжлийн агентлагийн Шүүхийн үр нөлөөний индекс (USAID: Judicial effectiveness index)¹²,
- НҮБ-ын Эрх зүйт ёсны индекс (UN: Rule of Law Index)¹³ зэрэг хамаарна.
- Шударга ёсны үр дүнтэй байдлын төлөөх Европын Комиссын Шударга ёсны чанарыг хэмжих аргачлал (European Commission for the Efficiency of Justice: Measuring the quality of justice)¹⁴

Ийнхүү олон улсын сайн туршлагыг судлахын зэрэгцээ Монгол Улсын өөрийн онцлог, практик нөхцөл байдал, өгөгдөл, мэдээллийн боломжтой байдлыг харгалзан үзэх үүднээс хуулийн салбарын тэргүүлэх мэргэжилтэн, судлаачид, шүүхийн байгууллагын холбогдох албаны ажилтнуудыг зөвлөлдөх багт урьж санал, шүүмжийг нь авч тусгалаа. Арга зүйн хувьд бусад олон улсын индексээс ялгаатай нь шүүхийн статистик, захиргааны мэдээллийг үндсэн эх сурвалжийн нэгт тооцон үнэлсэн бөгөөд эх хэл дээр боловсруулсан асуумж тул шинжээчдийн олон талт, өргөн хүрээтэй оролцоо хангагдсан хэмээн найдаж байна. Иймээс энэхүү индексийг бүхэлд нь төсөөллийн индекс гэж үзэж болохгүй юм.

Судалгааны цар хүрээг “шүүх эрх мэдэл” гэж өргөнөөр бус “шүүх” гэж тодорхой институтын хүрээнд авч үзсэн бөгөөд үүнд, бүх шатны шүүх, шүүхийн захиргааны болон шүүхийн хариуцлагын институтийг хамруулсан болно. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх

⁶ https://www.americanbar.org/advocacy/rule_of_law/publications/assessments/jri/

⁷ <https://worldjusticeproject.org/rule-of-law-index/>

⁸ <https://www.transparency.org/en/cpi/2021>

⁹ <https://www.weforum.org/reports/the-global-competitiveness-report-2020#report-nav>

¹⁰ <https://ncj.org/state-rankings/2021/justice-index>

¹¹ <https://freedomhouse.org/report/freedom-world>

¹² <https://measurebih.com/judicial-effectiveness-index>

¹³ https://www.un.org/ruleoflaw/files/un_rule_of_law_indicators.pdf

¹⁴ <https://rm.coe.int/1680747548>

ажиллагааны нөлөө бүхий оролцогч болох өмгөөлөл болон прокурорын байгууллагыг нөөц бололцооноос хамааран энэ удаад үнэлээгүй хэдий ч тодорхой хэмжигдэхүүний хүрээнд Үндсэн хуулийн хяналт, шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаарх төсөөлөл, мэдээллийг багтаалаа. Түүнчлэн олон улсад индексийг аль нэг хэмжигдэхүүнд тулгуурлаж, тухайлбал ил тод байдал, шударга, хараат бус байдал гэх зэргээр нэрлэдэг бол бид шүүхийн үйл ажиллагааг хэмжиж болохуйц бүх талын шалгуурыг багтаасан тул шүүхийн индекс хэмээн ерөнхийлөн нэрлэсэн болно.

2021 оны байдлаар олон нийтийн санал асуулга, салбарын шинжээчдийн буюу мэргэжилтнүүдийн санал асуулга, захиргааны мэдээлэл гэсэн үндсэн 3 эх сурвалжийн хүрээнд цуглуулсан мэдээллийг тоон илэрхийлэлд хувирган үнэлсэн энэхүү индексийн судалгаагаар манай улсын шүүх нийт боломжит 100 онооноос 51.94 оноог авлаа. Энэхүү нэгдсэн оноо нь (1) Шүүхийн эрх хэмжээ, бие даасан байдал, (2) Шүүхийн нээлттэй, ил тод байдал, (3) Шүүхэд итгэх олон нийтийн итгэл, (4) Шүүхийн дэд бүтэц, нөөц, (5) Шүүгчийн ёс зүй ба хариуцлага, (6) Шүүхийн үр ашигтай үйл ажиллагаа гэсэн 6 үндсэн хэмжигдэхүүн, түүнээс улбаалсан 42 дэд хэмжигдэхүүн, тэдгээрийг илэрхийлэх 108 шалгуур үзүүлэлтэд¹⁵ үндэслэн гарч байгаа бөгөөд үүнийг тайлангийн хөтөч болон арга зүй хэсгээс дэлгэрүүлэн харна уу. Үндсэн хэмжигдэхүүнийг тодорхойлох нь тус индексийн арга зүйн суурь байсан бөгөөд зөвлөлдөх багаар хэлэлцэн тодорхойлж гаргасан болно. Мөн арга зүйн хувьд нэгдсэн ерөнхий оноонд эдгээр хэмжигдэхүүн тэнцүү хувь эзэлж байгаа нь судалгааны баг хэмжигдэхүүнийг ач холбогдлын хувьд эрэмбэлэхээс зайлсхийсэнтэй холбоотой. Уншигчийн хувьд илүү чухал гэж үзсэн хэмжигдэхүүнийг дэд хэмжигдэхүүн, шалгуур үзүүлэлтийн түвшинд задлан ашиглах боломжтой.

2021 оны индексэд шүүхийн нээлттэй, ил тод байдал хамгийн өндөр буюу 62.30 оноо авсан бол шүүхийн дэд бүтэц, нөөц хамгийн бага 44.47 оноотой байна. Нийт 42 дэд хэмжигдэхүүнээс шүүгчийн сахилгын зөрчлийн гомдол, түүний шийдвэрлэлтийн талаарх мэдээллийн ил тод байдал хамгийн бага оноог буюу 30.00 оноо авсан бөгөөд хэрэг шийдвэрлэлтийн хувь хамгийн өндөр буюу 89.92 оноотой байна. Дэд хэмжигдэхүүн, шалгуур үзүүлэлт тус бүрээр олон нийт болон шинжээчдийн санал хэр зөрүүтэй байгааг дэлгэрүүлж харах боломжтойг дашрамд дурдъя.

Нээлттэй ил тод байдлын хувьд шүүхийн шийдвэр (72.35) болон шүүх хуралдааны нээлттэй байдал (75.32) -д өгсөн онооны байдлаар үндсэн хэмжигдэхүүний оноо өндөр гарсан нь 2012 оны шинэтгэлийн үр нөлөө гэж үзэж болно. Шүүхэд итгэх итгэлийн хувьд хуульч, өмгөөлөгч нарын шүүхэд итгэх итгэл олон нийтийн итгэх итгэлээс 2 орчим оноогоор илүү байгаа нь анхаарал татаж байна.

УИХ, Засгийн газрын зүгээс шүүхийн шинэтгэлийг дэмжих үйл ажиллагаандаа тус индексийн оноог хойш татаж буй тодорхой үзүүлэлтийг сайжруулахад тэргүүлэх ач холбогдол өгөх зэргээр ашиглах боломжтой юм. Жишээ нь, иргэдийн шүүхээр үйлчлүүлэх орчин нөхцөл дутмаг байгааг 32.34 оноотой шүүхийн байрны үнэлгээ харуулж байна.

Энэ мэтчилэн 108 шалгуур үзүүлэлт бүрээр гарсан оноо тус бүрийг шинжлэн үзэх боломжтой хэдий ч судалгааны багийн зүгээс аливаа дүгнэлт хийхийг зориогүй болно. Эдгээр онооны цаад учир шалтгааныг судлан таньж, үндэслэл бүхий шийдэл боловсруулах ажлыг шүүхийнхэн, бодлого боловсруулагчид болон судлаачдад үлдээлээ. Шүүхийн индексийн анхдагч өгөгдлийг нээлттэй өгөгдлийн сан хэлбэрээр нийтэлж байгаа бөгөөд judindex.forum.mn холбоосоор орж танилцах боломжтой.

¹⁵ Эдгээр шалгуур үзүүлэлтийн зарим нь дотроо хэд хэдэн үзүүлэлтээс бүрдсэн. Жишээ нь, "6.1. Шийдвэрлэгдээгүй хэргийн тоо" дэд хэмжигдэхүүний "6.1.1 Анхан шатны шүүхийн хүрээнд

шийдвэрлэгдээгүй хэргийн тоо бага байдаг." шалгуур үзүүлэлт нь хэргийн төрлөөс хамаарч 4 дэд үзүүлэлтээс бүрдсэн.

ХЯЗГААРЛАЛТ

- Шүүхийн индекс нь 2021 оны мэдээлэлд түлхүү үндэслэсэн хэдий ч асуумжийн хүрээнд 2020 оныг хамруулан асуусан тохиолдол бий.
- Монгол Улсын шүүхийн тухай хууль 2021 оны 01 дүгээр сарын 15-нд батлагдаж 2021 оны 3 дугаар сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэн хэдий ч 2021 оны 12 дугаар сар хүртэл Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны гишүүдийн томилгоо хийгдээгүй, шинэ хуулийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа эхлээгүй байсан тул энэ судалгаагаар шинэ хуулийн хэрэгжилтийг үнэлэх боломжгүй юм. Иймд судалгааг 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийн өмнөх үеийн үнэлгээ гэж ойлгож болно.
- Бүх индексүүдийн нэгэн адил энэхүү индексийг аливаа хувь хүний үнэт зүйлс, үзэл бодлын учир шалтгааны хамаарлыг тайлбарлахад ашиглахгүй. Энэхүү индексийн үнэлгээг Монгол Улсын шүүхийн цорын ганц бөгөөд бие даасан үнэлгээ гэж үзэх ёсгүй.
- Судалгааны баг индексийн оноог тооцоолох болон жинлэх, оноо өгөх арга зүйг боловсруулахад тэргүүлэх үүрэг гүйцэтгэж байсан ч санал асуулгад өгсөн хариултуудад ямар ч нөлөө үзүүлээгүй болно.

1.2 ШҮҮХИЙН ИНДЕКСИЙН ХӨТӨЧ

ШҮҮХИЙН ИНДЕКС ГЭЖ ЮУ ВЭ?

Шүүхийн индекс нь шүүхийн үйл ажиллагааг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу олон талаас нь бодитоор хэмжиж, үнэлэх хэрэгсэл юм.

ШҮҮХИЙН ИНДЕКСИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Шүүхийн индекс нь шүүхийн үйл ажиллагааг 6 үндсэн хэмжигдэхүүн, 42 дэд хэмжигдэхүүнд хуваагдсан 108 шалгуур үзүүлэлтээр хэмжсэн.

Зураг 2. Шүүхийн индексийн шалгуур үзүүлэлт

1 ШҮҮХИЙН ЭРХ ХЭМЖЭЭ, БИЕ ДААСАН БАЙДАЛ

Дэд хэмжигдэхүүн 7
Шалгуур үзүүлэлт 27

2 ШҮҮХИЙН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ

Дэд хэмжигдэхүүн 9
Шалгуур үзүүлэлт 16

3 ШҮҮХЭД ИТГЭХ ОЛОН НИЙТИЙН ИТГЭЛ

Дэд хэмжигдэхүүн 6
Шалгуур үзүүлэлт 19

4 ШҮҮХИЙН ДЭД БҮТЭЦ, НӨӨЦ

Дэд хэмжигдэхүүн 7
Шалгуур үзүүлэлт 15

5 ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ БА ХАРИУЦЛАГА


Дэд хэмжигдэхүүн 6
Шалгуур үзүүлэлт 12

6 ШҮҮХИЙН ҮР АШИГТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Дэд хэмжигдэхүүн 7
Шалгуур үзүүлэлт 19


ШҮҮХИЙН ИНДЕКСИЙН ОНОО

Шүүхийн индекс, түүний үндсэн хэмжигдэхүүн, дэд хэмжигдэхүүн, шалгуур үзүүлэлт бүрийг 0-100 оноогоор үнэлсэн. 0 оноо нь хамгийн сул, 100 оноо нь хамгийн сайн утгыг илэрхийлнэ.



ШҮҮХИЙН ИНДЕКСИЙН ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Шүүхийн индекс тооцсон шалгуур үзүүлэлтүүдийг (1) захиргааны мэдээлэл, (2) олон нийтийн төсөөллийн санал асуулга, (3) мэргэжилтнүүд (шүүгч, прокурор, өмгөөлөгч, бусад хуульч)-ийн санал асуулга гэсэн 3 төрлийн эх сурвалжаас бүрдүүлсэн.



ШҮҮХИЙН ИНДЕКСИЙН НЭЭЛТТЭЙ ӨГӨГДӨЛ

Шүүхийн индексийн тайлан болон нээлттэй өгөгдлийг judindex.forum.mn холбоосоор орж авах боломжтой



ШҮҮХИЙН ИНДЕКС

Үндсэн хэмжигдэхүүний оноо



1. ШҮҮХИЙН ЭРХ ХЭМЖЭЭ, БИЕ ДААСАН БАЙДАЛ



2. ШҮҮХИЙН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ



3. ШҮҮХЭД ИТГЭХ ОЛОН НИЙТИЙН ИТГЭЛ



4. ШҮҮХИЙН ДЭД БҮТЭЦ, НӨӨЦ




5. ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ БА ХАРИУЦЛАГА



6. ШҮҮХИЙН ҮР АШИГТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ШҮҮХИЙН ИНДЕКС

Ерөнхий оноо



Шүүхийн индекс
2021

100 оноо

Шүүхийн индекс 2021-ийн оноо

2.1 ЗОРИЛГО

2.2 ШҮҮХИЙН ИНДЕКСИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2.3 ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ

2.4 ШҮҮХИЙН ИНДЕКС ТООЦОХ АРГА ЗҮЙ

2

- ШҮҮХИЙН
ИНДЕКС
ТООЦОХ
АРГА ЗҮЙ

2.1 ЗОРИЛГО

Шүүхийн индекс нь шүүхийн шинэтгэлийн үйл явцад тогтмол, бодитой үнэлгээ өгөх, ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох зорилготой.

Шүүхийн индекс нь (1) шүүхийн үйл ажиллагааны төлөв байдлыг олон талаас бодитойгоор үнэлэх; (2) шалгуур

үзүүлэлтийн оноонд үндэслэн шүүхийн тулгамдсан асуудал, хүндрэл, бэрхшээлийг тодорхойлох; (3) төлөв байдал, тулгамдсан асуудлын үндсэн дээр шүүхийн хүрээнд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, чиг хандлагыг тодорхойлох чухал хэрэгсэл юм.

2.2. ШҮҮХИЙН ИНДЕКСИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Шүүхийн индекс нь үндсэн хэмжигдэхүүн, дэд хэмжигдэхүүн, шалгуур үзүүлэлт гэсэн 3 түвшний бүтэцтэй.

Шүүхийн индексийн хүрээнд 6 үндсэн хэмжигдэхүүн, 42 дэд хэмжигдэхүүнд хуваагдсан 108 шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон. Үндсэн хэмжигдэхүүн, дэд хэмжигдэхүүн, шалгуур үзүүлэлт тус бүрийг 0-ээс 100

оноогоор үнэлсэн бөгөөд 0 нь хамгийн сул, 100 нь хамгийн сайн гэсэн утгатай. Өөрөөр хэлбэл, индекс нь шүүх засаглалын өнөөгийн байдал хамгийн сулаас хамгийн сайн хувилбар хүртэлх зайд хэр хол байгааг хэмжих бөгөөд энэ удаагийн индексийн үр дүн нь дараагийн жилүүдэд тооцогдох индексийн үр дүнтэй харьцуулагдсанаар илүү тодорхой үнэлгээ болно.

Хүснэгт 1. Шүүхийн индексийн үндсэн хэмжигдэхүүн, дэд хэмжигдэхүүн, шалгуур үзүүлэлтийн тоо

№	Үндсэн хэмжигдэхүүн	Дэд хэмжигдэхүүний тоо	Шалгуур үзүүлэлтийн тоо
1.	Шүүхийн эрх хэмжээ, бие даасан байдал	7	27
2.	Шүүхийн нээлттэй, ил тод байдал	9	16
3.	Шүүхэд итгэх олон нийтийн итгэл	6	19
4.	Шүүхийн дэд бүтэц, нөөц	7	15
5.	Шүүгчийн ёс зүй ба хариуцлага	6	12
6.	Шүүхийн үр ашигтай үйл ажиллагаа	7	19
Нийт		42	108

ШҮҮХИЙН ИНДЕКСИЙН ҮНДСЭН ХЭМЖИГДЭХҮҮН

Индексийн 6 үндсэн хэмжигдэхүүнийг шүүхийн үйл ажиллагааг харьцангуй тодорхой илэрхийлэх боломжтой гэж үзэн дараах байдлаар тодорхойлов: 1) Шүүхийн эрх хэмжээ, бие даасан байдал; 2) шүүхийн нээлттэй, ил тод байдал; 3) шүүхэд итгэх олон нийтийн

итгэл; 4) шүүхийн дэд бүтэц, нөөц; 5) шүүгчийн ёс зүй ба хариуцлага; 6) шүүхийн үр ашигтай үйл ажиллагаа. Үндсэн хэмжигдэхүүн товч бөгөөд тодорхой байх нь дэд хэмжигдэхүүн, шалгуур үзүүлэлтийг нарийвчлахад дөхөмтэй юм.

1. ШҮҮХИЙН ЭРХ ХЭМЖЭЭ, БИЕ ДААСАН БАЙДАЛ

Шүүх бие даасан байх, шүүгч хараат бусаар, хөндлөнгийн аливаа зүй бус нөлөөллөөс ангид ажиллах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлын баталгаа.

2. ШҮҮХИЙН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ

Шүүхийн шийдвэр, үйл ажиллагаа олон нийтэд хүртээмжтэй байх, мэдээлэл авах боломж бүрдсэн байдал.

3. ШҮҮХЭД ИТГЭХ ОЛОН НИЙТИЙН ИТГЭЛ

Шүүх эрх мэдэл болон шүүгчийн мэдлэг, ур чадвар, ёс зүйд итгэх олон нийтийн итгэл, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны сэтгэл ханамжийн түвшин.

4. ШҮҮХИЙН ДЭД БҮТЭЦ, НӨӨЦ

Хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, хууль ёсны итгэлийг хамгаалахад буюу шүүхийн үйлчилгээг хэвийн, хүртээмжтэй явуулахад шаардлагатай хүний, санхүүгийн, материаллаг нөөцийн түвшин.

5. ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ БА ХАРИУЦЛАГА

Шүүгч хувийн ашиг сонирхлоос ангид байж, өндөр ёс зүйг чандлан сахих, шүүх бүрэн эрхээ хариуцлагатайгаар хэрэгжүүлэх, хариуцлага хүлээх чадвар.

6. ШҮҮХИЙН ҮР АШИГТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Шүүх хэргийг хугацаа алдалгүйгээр шийдвэрлэх чадвар, шүүхийн шийдвэрийн биелэлтийн түвшин.

ШҮҮХИЙН



ИНДЕКС



ДЭД ХЭМЖИГДЭХҮҮНИЙ ТАЙЛБАР

1. ШҮҮХИЙН ЭРХ ХЭМЖЭЭ, БИЕ ДААСАН БАЙДАЛ

Дэд хэмжигдэхүүн	Тайлбар
1.1. Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх	Хүн бүр шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргах, хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэх эрхтэй. Шүүх хүний хөрөнгө, орлого, нийгмийн гарал үүсэл, үндэс угсаа, байр суурь, улс төрийн үзэл баримтлал, нөлөөлөл, шашин шүтлэг, арьсны өнгө, бэлгийн чиг баримжаа, хүйсийн илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл зэргийг үл харгалзан алагчлалгүй, шударга ханддаг.
1.2. Хууль тогтоох эрх мэдэлд тавих шүүхийн хяналт	Үндсэн хуулийн цэц нь хууль, Улсын Их Хурлаас баталсан бусад шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэхийг тогтоох бүрэн эрхтэй бөгөөд бодит байдал дээр энэхүү эрх мэдлээ үр дүнтэй хэрэгжүүлдэг.
1.3. Гүйцэтгэх эрх мэдэлд тавих шүүхийн хяналт	Шүүх захиргааны байгууллагын захирамжилсан шийдвэр, үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт тавьдаг бөгөөд бодит байдал дээр энэхүү эрх мэдлээ үр нөлөөтэй хэрэгжүүлдэг.
1.4. Шүүхийн бие даасан байдал	Шүүхийн бие даасан байдлыг улс төрийн түвшинд хүлээн зөвшөөрдөг, шүүхийн төсөв хангалттай, хүрэлцээтэй, гүйцэтгэх эрх мэдэл шүүхийн шийдвэрийг хүндэтгэн биелүүлдэг.
1.5. Шүүгчийн хараат бус байдал	Шүүгч аливаа улс төрийн болон хувийн ашиг сонирхлоос ангид байж, эрх мэдлээ хэтрүүлэн ашигладаггүй, хуулийн дагуу хараат бусаар хэрэг, маргааныг хянан шийдвэрлэдэг. Шүүгчийн хараат бус байдлыг хуулиар баталгаажуулж, бодит байдал дээр хэрэгжүүлдэг.
1.6. Шүүхийн ерөнхий зөвлөл	Шүүхийн ерөнхий зөвлөл нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, улс төрч болон бусад аливаа этгээдээс хараат бусаар ажиллаж, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүгчдийн эрх, ашгийг хамгаалах талаар идэвхтэй ажилладаг.
1.7. Шүүх, шүүгчийн аюулгүй байдал	Шүүхийн байр хамгаалалтад байж, шаардлагатай үед шүүгч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг хангадаг, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах үр дүнтэй тогтолцоо, эрх зүйн орчин, нөөц бололцоо бүрдсэн.

2. ШҮҮХИЙН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ

Дэд хэмжигдэхүүн	Тайлбар
2.1. Шүүгчийн сонгон шалгаруулалт	Шүүгчийн сонгон шалгаруулалт нээлттэй, ил тод явагддаг. Шүүгчийн сонгон шалгаруулах процесс, нэр дэвших явцын тухай мэдээлэл олон нийтэд нээлттэй байршдаг, шүүгч сонгон шалгаруулах бүрэн эрх бүхий байгууллагын эцсийн үнэлгээ, үнэлгээний задаргаа, тайлбар нээлттэй, ил тод байдаг.
2.2. Хууль тогтоомж	Шүүх эрх мэдлийн хүрээнд мөрдөж буй хууль тогтоомж нээлттэй, ил тод, хүн бүрт хүртээмжтэй байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд, тухайлбал, бүрэн буюу сул хараатай иргэнд зориулан сонсох, эсхүл бусад боломжит хувилбараар байршуулсан байдаг.
2.3. Шүүхийн тайлан, статистик	Шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тайлан, статистик мэдээлэл нээлттэй, ил тод, ойлгомжтой, олж уншихад хялбар байдаг.
2.4. Шүүх хуралдаан	Нээлттэй шүүх хуралдаанд аливаа хүнд суртал, олон шат дамжлагаар дамжилгүй оролцох, үзэх боломжтой байдаг.
2.5. Шүүхийн шийдвэр	Төрийн болон албаны, хувь хүний нууцад хамаарах, түүнчлэн хэргийн оролцогчийн хүсэлтээр шүүхийн шийдвэрийн цахим санд оруулаагүйгээс бусад шүүхийн шийдвэр олон нийтэд нээлттэй, ил тод байдаг. Мөн шүүхийн шийдвэрийн олон нийтэд зориулсан хураангуй ойлгомжтой, хүртээмжтэй байдаг.
2.6. Хэргийн материалтай танилцах	Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч хэргийн материалтай цаг тухайд нь бүрэн, хугацаанд баригдалгүй танилцах боломжтой байдаг.
2.7. Хэрэг, нэхэмжлэлийн хуваарилалт	Шүүх дэх хэрэг, нэхэмжлэлийн хуваарилалт нээлттэй, ил тод бөгөөд энэ талаар мэдээлэл авах боломжтой байдаг.
2.8. Шүүхийн төсвийн ил тод байдал	Шүүхийн төсвийн зарцуулалтын тайлан, түүний задаргаа нээлттэй, ил тод байдаг.
2.9. Хэвлэл мэдээллийн сурвалжилга	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мөрдөн байцаалтын болон шүүхийн шатанд байгаа хэрэг, маргааныг бодитойгоор сонгож танилцуулдаг.

3. ШҮҮХЭД ИТГЭХ ОЛОН НИЙТИЙН ИТГЭЛ

Дэд хэмжигдэхүүн	Тайлбар
3.1. Шүүхийн тогтолцоо	Шүүгч хэрэг, маргааныг хууль дээдлэх зарчмыг баримтлан хууль ёсны, үндэслэлтэй шийдвэрлэдэг ба хэрэг, маргааныг өөрийн хүссэн шүүгчээр шийдвэрлүүлэх боломжгүй байдаг.
3.2. Шүүгчийн шударга байдал	Шүүгч хуулийг зөв тайлбарлан хэрэглэж, хэргийн оролцогчдын аль ч талд хүлээн зөвшөөрөгдөхөөр үндэслэлтэй шийдвэр гаргадаг.
3.3. Шүүгчийн зан суртахуун	Шүүгч хэргийн оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэдэг, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л шатанд оролцогчидтой зохих ёсоор, хүндэтгэлтэй харилцдаг.
3.4. Шүүгчийн мэдлэг, ур чадвар	Шүүгч хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хангалттай хэмжээний онолын болон практик мэдлэг, ур чадвартай.
3.5. Шүүхийн процессын сэтгэл ханамж	Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхийн үйлчилгээ ойлгомжтой, хүртээмжтэй, найрсаг байдаг тул шүүхийн шийдвэр хэний талд гарахаас үл хамаарч сэтгэл ханамжтай үлддэг.
3.6. Шүүхийн шийдвэрийн үндэслэл	Шүүгч шүүхийн шийдвэрээ хоёрдмол утгагүй, ойлгомжтой, үндэслэл бүхий, хэл зүй, найруулга зүйн хувьд өндөр түвшинд бичдэг.

4. ШҮҮХИЙН ДЭД БҮТЭЦ, НӨӨЦ

Дэд хэмжигдэхүүн	Тайлбар
4.1. Шүүгчийн сонгон шалгаруулалт	Шүүгчийг гагцхүү мэдлэг, ур чадвар, ёс зүйд нь үндэслэн өндөр босготой, шударга сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилдог.
4.2. Шүүгчийн мэдлэг, ур чадвар	Шүүгч онолын болон практик мэдлэгээ зохих ёсоор ашигладаг, хэрэг, маргааныг хууль ёсны, үндэслэлтэй шийдвэрлэх ур чадвартай.
4.3. Шүүгчийн цалин хөлс	Шүүгчийн цалин хөлс нь үндсэн ажлаа эргэлзээгүй, бүрэн дүүрэн гүйцэтгэхэд хангалттай бөгөөд аливаа хэрэгцээнд нь хүрэлцээтэй, бусад орлогын эх үүсвэрийг ашиглах шаардлагагүй байдаг.
4.4. Шүүхийн захиргааны ажилтан	Шүүхийн захиргааны туслах ажилтнууд харилцааны болон гүйцэтгэлийн өндөр ур чадвартай бөгөөд шүүгч ажил үүргээ хэвийн явуулахад шаардлагатай хүний нөөцийн орон тоотой байдаг.
4.5. Шүүхийн барилга байгууламж	Шүүх үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн явуулахад зориулсан барилга байгууламжтай ба шүүх хурлын танхим багтаамж сайтай, зөвлөлдөх тасалгаа, бусад шаардлагатай өрөө хүрэлцээтэй байдаг.
4.6. Шүүхийн мэдээллийн технологи	Шүүхийн үйл ажиллагаанд ашиглах мэдээллийн технологийн програм хангамж нь лицензтэй, хүчин чадал өндөртэй, аливаа халдлагаас хамгаалах чадвартай бөгөөд мэдээллийн технологийн бусад хэрэгсэл тоо хэмжээний хувьд хангалттай, хүртээмжтэй байдаг.
4.7. Эрсдэлийн удирдлагын тогтолцоо	Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийг даван туулах эрсдэлийн удирдлагын тогтолцоотой бөгөөд цаг үеийн нөхцөл байдалд хурдан дасан зохицох, үйл ажиллагаагаа уялдуулах чадавхтай.

5. ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ БА ХАРИУЦЛАГА

Дэд хэмжигдэхүүн	Тайлбар
5.1. Шүүгчийн ажлын гүйцэтгэл	Шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л шатанд хуульд заасан хугацааг нягт баримталдаг бөгөөд хэргийн оролцогчдоос гаргасан аливаа хүсэлт, гомдлыг хугацаанд нь, зохих ёсоор шийдвэрлэдэг. Аливаа асуудлаар хүсэлт, гомдлыг хангаагүй шийдвэр гаргасан бол үндэслэлээ тодорхой дурддаг, тайлбарладаг.
5.2. Шүүгчийн хариуцлагын тогтолцоо	Шүүхийн Ёс зүйн хороо хуульд заасан чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлж, сахилгын зөрчилд холбогдсон шүүгчийн хэргийг хууль ёсны, үндэслэлтэй, хараат бусаар шийдвэрлэж чаддаг.
5.3. Шүүгчийн сахилгын зөрчлийн процесс	Шүүгчийн сахилгын зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа хуульд заасан журмын дагуу, хараат бус явагддаг, сахилгын хэрэгт холбогдох этгээдийн оролцоог хангаж чаддаг.
5.4. Сахилгын шийтгэл	Шүүхийн сахилгын хороо шүүгчид холбогдох сахилгын хэргийг хянан шийдвэрлээд үндэслэлтэй, тухайн хэрэгт тохирсон шийдвэр гаргаж чаддаг.
5.5. Шүүгчийн ёс зүй	Шүүгч шүүгчийн мэргэжлийн ёс зүйг чанд баримталж, шүүх эрх мэдэлд төдийгүй олон нийтэд үлгэр дуурайл болж чаддаг.
5.6. Шүүгчтэй холбоотой гомдлын мэдээлэл	Шүүгчийн эсрэг гаргасан гомдол, түүний төрөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээлэл нийтэд нээлттэй, ил тод байдаг.

6. ШҮҮХИЙН ҮР АШИГТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Дэд хэмжигдэхүүн	Тайлбар
6.1. Шийдвэрлэгдээгүй хэргийн тоо	Хуанлийн жилд шийдвэрлэгдээгүй хэргийн тоо буюу хэргийн үлдэгдэл бага байдаг.
6.2. Хэрэг шийдвэрлэлтийн хувь	Хуанлийн жилд шүүх шинээр үүсгэсэн буюу хүлээн авсан хэргийг ихэнхийг нь шийдвэрлэж дуусгадаг.
6.3. Шүүгчийн ажлын ачаалал	Шүүгчийн ажлын ачаалал тэнцвэртэй бөгөөд түүний нөөц бололцоо, бодит боломжид тохирсон тоогоор хэрэг, маргаан хуваарилагддаг.
6.4. Шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал	Шүүхийн шийдвэр тогтвортой ба анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хяналтын шатны шүүхийн тогтоолоор ихэнхдээ хэвээр үлдээж шийдвэрлэдэг.
6.5. Шүүхийн үр ашгийн тухай төсөөлөл	Шүүх хуулиар олгосон эрх мэдлээ зохих ёсоор хэрэгжүүлдэг, шүүх эрх мэдлийн үйл ажиллагаа үр нөлөөтэй байдаг.
6.6. Шүүхийн захиргааны үйлчилгээ	Шүүхийн захиргааны үйлчилгээ шүүхээр үйлчлүүлж буй олон нийтэд ээлтэй, хүртээмжтэй, ойлгомжтой байдаг бөгөөд шүүхээр үйлчлүүлсэндээ сэтгэл ханамжтай үлддэг.
6.7. Шүүхийн шийдвэрийн биелэлт	Шүүхийн шийдвэрийг холбогдох этгээд сайн дураараа дагаж биелүүлдэг бөгөөд шүүхийн шийдвэрийн биелэлт өндөр байдаг.

2.3. ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Шүүхийн индексэд 6 үндсэн хэмжигдэхүүн, 42 дэд хэмжигдэхүүн, нийт 108 шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон бөгөөд индекс боловсруулахад гагцхүү нэг эх сурвалжаас, нэг шалгуур үзүүлэлтээр өгөгдөл, мэдээлэл цуглуулах нь хангалтгүй гэж үзэж, аль болох мэдээллийн олон эх сурвалжийг ашиглахыг хичээсэн болно. Индексийн тооцоололд багтсан бүх үзүүлэлтүүдийг өгөгдлийн 3 эх сурвалж (захиргааны мэдээлэл, олон нийтийн төсөөллийн санал асуулга, мэргэжилтнүүд (шүүгч, прокурор, өмгөөлөгч, бусад хуульч)-ийн санал асуулга)-ийг ашиглан боловсруулсан. Ингэснээр ижил асуудлын

талаарх өөр өөр үзэл бодлыг иж бүрэн, харьцуулан танилцуулах боломжийг олгох бөгөөд хэт өрөөсгөл, нэг талыг баримталсан ойлголт, төсөөллийг бууруулсан. Ялангуяа шалгуур үзүүлэлтүүдэд олон нийтийн төсөөлөл болон мэргэжилтнүүдийн санал бодлын аль алиныг багтаахыг хичээсэн. Санал асуулгын асуулт, бодомжийг тодорхойлохдоо шүүхийн индексийн үндсэн хэмжигдэхүүн, дэд хэмжигдэхүүнд үндэслэн тэдгээрт хамааралтайгаар боловсруулсан бөгөөд бодомж нь дэд хэмжигдэхүүний утгын агуулгыг алдагдуулахгүй байхад анхаарсан.

Хүснэгт 2. Шүүхийн индексийн шалгуур үзүүлэлтийн тоо, өгөгдлийн эх сурвалжаар

№	Үндсэн хэмжигдэхүүн	Дэд хэмжигдэхүүн	Олон нийтийн санал асуулга	Мэргэжилтнүүдийн санал асуулга	Захиргааны мэдээлэл	Шалгуур үзүүлэлт
1.	Шүүхийн эрх хэмжээ, бие даасан байдал	7	9	18	0	27
2.	Шүүхийн нээлттэй, ил тод байдал	9	7	8	1	16
3.	Шүүхэд итгэх олон нийтийн итгэл	6	10	9	0	19
4.	Шүүхийн дэд бүтэц, нөөц	7	5	10	0	15
5.	Шүүгчийн ёс зүй ба хариуцлага	6	3	8	1	12
6.	Шүүхийн үр ашигтай үйл ажиллагаа	7	3	2	14	19
Нийт		42	37	55	16	108

ОЛОН НИЙТИЙН САНАЛ АСУУЛГА

Газар зүйн байршил, нутаг дэвсгэрийн онцлогоос хамаарч асуумжийн хариу хот болон орон нутгийн хэмжээнд өөр өөр гарах боломжтой тул олон нийтийн санал асуулгын түүврийг тодорхойлохдоо Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу нэгж тус бүрийн төлөөллийг хамруулсан.

Олон нийтээс санал асуулга авах ажлыг зөвлөх үйлчилгээний “Эм Эм Си Жи” ХХК-иар гүйцэтгүүлсэн. Үндэсний статистикийн хорооны 2020 оны Хүн ам, орон сууцны ээлжит тооллогын дүнгээр Монгол Улсын 18-аас дээш насны нийт хүн амын тоо 2,043,062 байна. Энэ нь нийт хүн амын 64%-ийг бүрдүүлж байна. Түүврийн хэмжээг 95%-ийн итгэх завсарт, 2.1%-ийн алдааны түвшинтэйгээр тооцоход түүврийн хэмжээ 2007 буюу ойролцоогоор 2000 байна.

$$n = \frac{Z^2 p(1-p)}{e^2} \quad n = \frac{(1.96)^2 (0.64)(1-0.64)}{0.021^2}$$

Энд: n – түүврийн хэмжээ, Z – хүсэж буй итгэх түвшин дэх Z утга, p – тухайн үзэгдлийн илрэх магадлал, e – хүлээн зөвшөөрөгдөх алдааны түвшин

Олон нийтийн санал асуулгад Улаанбаатар хот болон 21 аймаг, 330 сумын төлөөлөл болсон 18-аас дээш

МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН САНАЛ АСУУЛГА

Мэргэжилтнүүдийн санал асуулгын дүн нь шүүхийн мэргэжлийн үйл ажиллагааны чухал шалгуур үзүүлэлтийг харуулах тул санал асуулгад хамрагдах мэргэжилтнүүдийг тодорхойлохдоо шүүхийн үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар хамааралтай болох үүднээс шүүгч, прокурор, өмгөөлөгч, бусад хуульчдаас асуулга авсан.

“Оюуны-Инноваци” ТББ-аас 2020 оны 02 дугаар сард мэргэжилтнүүдийн санал асуулгыг цахим хэлбэрээр явуулсан. Асуумжийн линкийг зөвхөн шүүгчдийн байдаг фэйсбүүк группт байршуулах, асуулгад оролцох талаар бүх шүүгч рүү мессеж илгээх зэрэг аргаар

ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ

Манай улсын шүүх засаглал өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд мэдээллийн удирдлагын системийг нэвтрүүлж, хөгжүүлэхэд ихээхэн хүчин чармайлт гаргасан. Үүний үр дүнд бүх шүүхэд хэргийн удирдлагын систем нэвтэрч, хангалттай бөгөөд бодитой мэдээллийн бааз суурьтай болсон. Мэдээллийг хэргийн төрөл, түүнчлэн анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхээр ангилан гаргах боломжтой. Иймд энэхүү эх сурвалжаас шийдвэрлэгдсэн хэргийн тоо, хуримтлагдсан хэргийн тоо, хэрэг шийдвэрлэлтийн хувь хэмжээний талаарх мэдээллийг цуглуулсан.

“Оюуны-Инноваци” ТББ-аас мэдээлэл авах тухай албан хүсэлтээр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүхээс хэрэг

$$n = \frac{0.8851}{0.000441} = 2007 \quad n \approx 2000$$

насны 2016 иргэнийг хамруулан 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс 12 дугаар сарын 14-ний өдрийн хугацаанд утсаар-CATI аргаар хийж гүйцэтгэсэн. 108 шалгуур үзүүлэлтээс 37-г нь олон нийтийн төсөөллийн санал асуулгаар үнэлэв.

шүүгчдээс асуумж авах ажиллагааг хийсэн. Нийт 99 шүүгч хариулт илгээв. Прокуророос авах асуумжийг Улсын ерөнхий прокурорын газрын тусламжтайгаар зохион байгуулсан. Нийт 138 прокурор хариулт илгээв. Өмгөөлөгч болон бусад хуульчдаас авах асуумжийн линкийг хуульчид байдаг фэйсбүүк группт байрлуулах аргаар авсан ба нийт 88 өмгөөлөгч, 62 бусад хуульчид хариулт илгээв. Ингэснээр нийт 387 мэргэжилтнээс хариулт авсан байна. Индексийн хүрээнд 108 шалгуур үзүүлэлтээс 55-ыг нь мэргэжилтнүүдийн санал асуулгаар үнэлэв. Шүүхэд итгэх олон нийтийн итгэл хэсэгт мэргэжилтний санал асуулгыг ашиглахдаа шүүгчдийн хариуг хасаж тооцсон болно.

шийдвэрлэсэн талаарх статистик мэдээлэл; шүүхийн шийдвэрийн тогтвортой байдлын талаарх мэдээлэл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас иргэн, захиргаа, эрүүгийн хэрэгт гаргасан шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн биелэлтийн 2019-2021 оны статистик мэдээллийг тус тус авсан. Мөн 2017-2021 онд гарсан Монгол Улсын шүүхийн тайлан, холбогдох бусад судалгааны эх сурвалжаас мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийсэн. Индексийн 108 шалгуур үзүүлэлтээс 16 шалгуур үзүүлэлтийг захиргааны мэдээллээр үнэлэв.

2.4. ШҮҮХИЙН ИНДЕКС ТООЦОХ АРГА ЗҮЙ

ШҮҮХИЙН ИНДЕКС ТООЦОХ ҮНДСЭН АЛХАМ

1. Өгөгдөл цуглуулах

Индекс тооцоход шаардлагатай өгөгдлийг захиргааны мэдээлэл, олон нийтийн төсөөллийн санал асуулга, мэргэжилтнүүдийн санал асуулга гэсэн 3 төрлийн эх сурвалжаар цуглуулна. Санал асуулгын асуулт бүрийн хариултыг урьдчилж тоон утгаар кодлосон байна.

Бүх асуултын хариултыг бага утгаас (шүүхийн үйл ажиллагаа сул) их утга (шүүхийн үйл ажиллагаа сайн) хүртэл нэгдсэн дараалалд оруулан нормализаци хийх шатанд бэлтгэнэ. Асуултын агуулгаас хамаарч зарим асуултын хариултыг урвуу дараалалд оруулна.

2. Өгөгдлийг цэвэрлэх, нормализаци хийх

Дутуу бөглөсөн, асуултад нэгээс илүү хариулт өгсөн, эсвэл “мэдэхгүй” гэж хариулт өгсөн асуулгыг хүчингүйд тооцон индекс боловсруулалтанд хамруулахгүй.

Өгөгдлийн санг үр ашигтайгаар зохион байгуулах, хэмжигдэхүүн хоорондын утгыг нэгдсэн байдлаар харьцуулах боломжийг бий болгох зорилгоор хариулт бүрийг 0-ээс 1 хүртэлх утгын хооронд нормализаци (min-max normalization) хийнэ. Томъёо:

$$z_i = \frac{x_i - \min(x)}{\max(x) - \min(x)}$$

z_i – Нормалчилсан x_i утга

x_i – Асуумжийн хариулт

$\max(x)$ – x дахь хамгийн их утга

$\min(x)$ – x дахь хамгийн бага утга

3. Шалгуур үзүүлэлтийн оноо тооцох

Өгөгдлийг нормализаци хийсний дараа шалгуур үзүүлэлт бүрийн дундаж утгыг тооцно. Шалгуур үзүүлэлтийн дундаж утгыг 0-100 хүртэлх индексийн оноонд хөрвүүлнэ.

4. Дэд хэмжигдэхүүний оноо тооцох

Дэд хэмжигдэхүүний оноог тооцохдоо шалгуур үзүүлэлт бүрийн холбогдох жинг харгалзан дундаж оноог тооцно.

5. Үндсэн хэмжигдэхүүний оноо тооцох

Үндсэн хэмжигдэхүүний оноог тооцохдоо дэд хэмжигдэхүүн бүрийн холбогдох жинг харгалзан дундаж оноог тооцно.

6. Индексийн ерөнхий оноо тооцох

Үндсэн хэмжигдэхүүн бүрийн холбогдох жинг харгалзан дундаж оноог тооцсоноор индексийн ерөнхий оноог гарган авна.

ЖИНЛЭХ АРГА ЗҮЙ

Индексийн боловсруулалтын чухал хэсэг нь индексийн (1) үндсэн хэмжигдэхүүн, (2) үндсэн хэмжигдэхүүн доторх дэд хэмжигдэхүүн, (3) дэд хэмжигдэхүүн доторх шалгуур үзүүлэлтэд хамаарах олон төрлийн, ялгаатай мэдээллийн эх сурвалжийг жинлэж үр дүнг гаргах явдал юм. Судалгааны баг индекс дэх үндсэн хэмжигдэхүүний эзлэх жинг тэнцүү буюу шүүхийн эрх хэмжээ, бие даасан байдал 16.67%, шүүхийн нээлттэй, ил тод байдал 16.67%, шүүхэд итгэх олон нийтийн итгэл 16.67%, шүүхийн дэд бүтэц, нөөц 16.67%, шүүгчийн ёс зүй ба хариуцлага 16.67%, шүүхийн үр ашигтай үйл ажиллагаа 16.67% байхаар тооцно.

Дэд хэмжигдэхүүний үндсэн хэмжигдэхүүн дотор эзлэх жинг тэнцүү хувиар тооцсон. Мөн дэд хэмжигдэхүүн доторх шалгуур үзүүлэлтийн эзлэх жинг тэнцүү

тооцсон ба ингэхдээ дараах зарчмыг баримтална:

1. Зөвхөн нэг шалгуур үзүүлэлттэй дэд хэмжигдэхүүний хувьд (олон нийтийн санал асуулга эсхүл мэргэжилтнүүдийн санал асуулга, эсхүл захиргааны мэдээлэл) тухайн шалгуур үзүүлэлтийн дэд хэмжигдэхүүнд эзлэх жинг 100 хувь гэж үзнэ.

2. Хоёр буюу түүнээс дээш шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх дэд хэмжигдэхүүний хувьд (захиргааны мэдээлэл болон олон нийт, мэргэжилтнүүдийн санал асуулга, тэдгээрийн хослол) шалгуур үзүүлэлт бүрийн дэд хэмжигдэхүүнд эзлэх жинг тэнцүү тооцно. Жишээ нь, 2 шалгуур үзүүлэлтийн эзлэх жинг тус бүрд нь 50%, 3 шалгуур үзүүлэлтийн жинг тус бүрд нь 33.33% гэж тооцно.


Хүснэгт 3. Үндсэн хэмжигдэхүүний индекст эзлэх жин

№	Үндсэн хэмжигдэхүүн	Дэд хэмжигдэхүүний тоо	Шалгуур үзүүлэлтийн тоо	Эзлэх жин
1.	Шүүхийн эрх хэмжээ, бие даасан байдал	7	27	16.67%
2.	Шүүхийн нээлттэй, ил тод байдал	9	16	16.67%
3.	Шүүхэд итгэх олон нийтийн итгэл	6	19	16.67%
4.	Шүүхийн дэд бүтэц, нөөц	7	15	16.67%
5.	Шүүгчийн ёс зүй ба хариуцлага	6	12	16.67%
6.	Шүүхийн үр ашигтай үйл ажиллагаа	7	19	16.67%
Нийт		42	108	100%

ОНОО ӨГӨХ АРГА ЗҮЙ

- Шүүхийн индекс нь 0-100 оноогоор хэмжигдэнэ.
- 0 нь хамгийн сул утгыг, 100 нь хамгийн сайн утгыг илэрхийлнэ.
- Шалгуур үзүүлэлтүүдийн онооны жигнэсэн дунджаар

индексийн дэд хэмжигдэхүүний оноог тооцох ба дэд хэмжигдэхүүний жигнэсэн дунджаар индексийн үндсэн хэмжигдэхүүний оноог, үндсэн хэмжигдэхүүний онооны жигнэсэн дунджаар индексийн ерөнхий оноог тооцно.



САНАЛ АСУУЛГААР ЦУГЛУУЛСАН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ОНОО ТООЦОХ

Судалгааны асуултуудын хариултыг тоон утгаар кодлож, нормализаци хийж дундаж утгыг тооцсоны дараа 0-100 оноонд хөрвүүлж индексийн оноог тооцно.

Хүснэгт 4-д 5 сонголттой судалгааны асуултын оноо тооцох жишээг үзүүлэв.

Хүснэгт 4. Судалгааны хариултанд оноо өгсөн аргачлалын жишээ

Жишээ нь, ОНСА 4.1: Хүн бүр Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн

гэж үзвэл шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргах, хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэх эрхээр хангагдсан байдаг.

Хариултын сонголт	Хариултын тоон утга	Нормализаци хийсэн утга	Судалгаанд оролцогчдын тоо	Шалгуур үзүүлэлтийн индексийн оноо
	(x_i)	$z_i = \frac{x_i - \min(x)}{\max(x) - \min(x)}$	(n)	$\mu = \frac{\sum_{i=1}^n z_i}{N}$
1. Бүрэн санал нийлнэ	5	1	384	60.62
2. Санал нийлнэ	4	0.75	413	
3. Зарим талаар санал нийлнэ	3	0.50	879	
4. Санал нийлэхгүй	2	0.25	329	
5. Огт санал нийлэхгүй	1	0	0	
6. Мэдэхгүй	-	-	11	
Нийт	N = 2016 – 11 = 2005			

Тайлбар:

Олон нийтийн төсөөллийн санал асуулгын 4.1 дүгээр асуултын хариултыг нэгтгэн хэрхэн индексийн оноонд хөрвүүлсэн талаар дэлгэрэнгүй тайлбарлая.

ОНСА 4.1: Хүн бүр Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргах, хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэх эрхээр хангагдсан байдаг.

Судалгаанд нийт 2016 хүн хамрагдсан бөгөөд олон нийтийн төсөөллийн санал асуулгын 4.1 дүгээр асуултад 384 хүн “Бүрэн санал нийлнэ”, 329 хүн “Санал нийлнэ”, 879 хүн “Зарим талаар санал нийлнэ”, 413 хүн “Санал нийлэхгүй”, 11 хүн “Мэдэхгүй” гэж хариулсан байна.

Шүүхийн үйл ажиллагааны төлөв байдлыг бодитойгоор үнэлэх зорилгоор асуултад “Мэдэхгүй” гэж хариулсан оролцогчдын хариултыг индекс тооцоход оруулахгүй. Ингэснээр ОНСА 4.1 асуултын “Мэдэхгүй” гэж хариулсан 11 хариултыг хасан 2005 хүний хариултыг индекс тооцоход ашиглана.

Шалгуур үзүүлэлтийн индекс нь 0-100 онооны хооронд байх бөгөөд, 0 оноо нь шүүх засаглалын төлөв байдал маш сул гэж үзэх бол 100 оноо нь шүүх засаглалын төлөв байдал маш сайн гэж илтгэнэ. Шалгуур үзүүлэлтийн индексийн оноог тооцох дараалал:

1. Хариултуудыг тоон утгад шилжүүлнэ. Хүн бүр Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргах, хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэх эрхээр хангагдсан байдаг гэдэгтэй “Огт санал нийлэхгүй” гэж хариулсан иргэдийн хариултыг хамгийн бага тоон утга буюу 1 гэж кодлоно. “Санал нийлэхгүй” хариултыг 2, “Зарим талаар санал нийлнэ” хариултыг 3, “Санал нийлнэ” хариултыг 4, “Бүрэн санал нийлнэ” хариултыг 5 гэж кодлоно. “Мэдэхгүй” хариултыг индекс тооцоход оруулахгүй.

2. Кодлосон хариултуудыг дараах томъёогоор нормализаци хийж, 0-1 тоон утгад хөрвүүлнэ.

$$z_i = \frac{x_i - \min(x)}{\max(x) - \min(x)}$$

z_i – Нормализаци хийсэн x_i утга

x_i – Асуултын хариулт

$\max(x)$ – x дахь хамгийн их утга

$\min(x)$ – x дахь хамгийн бага утга

ОНСА 4.1 асуултын хувьд 5 хариулттай бөгөөд, хариулт бүрийг өмнө нь тоон утгаар кодлоно. Хариултын хамгийн бага утга нь 1 бөгөөд хамгийн их утга нь 5. Санал асуулгад оролцсон нийт 2005 хүний хариултын нормализацийг дараах томъёогоор тус бүр тооцно:

$$z_i = \frac{x_i - 1}{5 - 1} = \frac{x_i - 1}{4}$$

3. Хариултуудын нормализаци хийсэн тоон утгыг ашиглан судалгааны асуулт буюу тухайн шалгуур үзүүлэлтийн дундаж оноог дараах томъёогоор тооцно.

$$\mu = \frac{\sum_{i=1}^N z_i}{N}$$

ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЛЭЭР ҮНЭЛЭГДЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ОНОО ӨГСӨН АРГАЧЛАЛ

Захиргааны мэдээллийн цогц, үнэн зөв байх нь маш том давуу тал байсан ч тэдгээрийг индекс хөрвүүлэх нь төвөгтэй байв. Тодруулбал, Захиргааны мэдээллээс авсан үзүүлэлтүүдийн бодит утгыг индекс рүү хөрвүүлж 0-100 оноогоор индексжүүлсэн. Ингэхдээ 2021 оны үзүүлэлттэй харьцуулж цаашдын ахиц дэвшлийг хэмжих тул хамгийн сайн хувилбарыг («утопи») тодорхойлсон болохыг тэмдэглэж байна.

Судалгааны баг захиргааны мэдээллийг индексийн оноо болгон хөрвүүлэх (масштаблах) хувилбар, аргачлалуудыг судалсан. Үүний хүрээнд Шударга ёсны үр дүнтэй байдлын төлөөх Европын Комисс (European Commission for the Efficiency of Justice)-ын аргачлал¹⁶, АНУ-ын Хөгжлийн агентлагийн Шүүхийн үр нөлөөний индексийн аргачлалыг гол болгосон. Ийнхүү 2018-2021 оны захиргааны мэдээлэлд нарийвчилсан дүн шинжилгээ хийсний дараа судалгааны баг доор тайлбарласны дагуу захиргааны мэдээллийг индексийн оноонд шилжүүлэх 3 аргачлалыг ашигласан болно.

Аргачлал 1: Судалгааны баг эхлээд 2018-2021 оны захиргааны мэдээллийг Шүүхийн ерөнхий зөвлөл болон Монгол Улсын шүүхийн 2018-2021 оны тайлангаас гаргаж авсан. Эдгээр мэдээллийг шалгуур үзүүлэлтийн онооны дундаж утга (жишээ нь, 0-100 утга дээр 50)-ыг тооцоолоход ашигласан. Хамгийн сайн үнэлгээг бодит утгаар 0 (индексийн оноо 100) гэж, харин хамгийн сул үнэлгээг (индексийн оноо 0) дундаж утгаас хоёр дахин их байхаар тогтооно. Өөрөөр хэлбэл, 2021 оны хамгийн сул үнэлгээ нь 2018-2020 оны дундаж үзүүлэлтээс хоёр дахин их байна.

Жишээ нь, 2018-2020 онд анхан шатны шүүхийн хүрээнд шийдвэрлэгдээгүй захиргааны хэргийн дундаж тоо 300 байсан гэж тооцвол үүнийг 2 дахин үржүүлж гаргасан 600 нь хамгийн сул үр дүн (индексийн оноогоор 0), харин хэргийн үлдэгдэлгүй буюу 0 байх нь хамгийн сайн (индексийн оноогоор 100) үр дүн, дундаж тоо 300 нь индексийн үнэлгээгээр 50.00 болно. Үүнийг индекс хөрвүүлж 2021 оны үр дүнг гаргахад 2021 оны бодит утга (шийдвэрлэгдээгүй

Хүснэгт 5: Аргачлал 1. Захиргааны мэдээлэлд оноо өгсөн аргачлалын жишээ

Бодит утга (тоогоор)	Индексийн оноо (0-100)	Тайлбар
0	100	Хамгийн сайн
60	90	
120	80	
240	60	2021 оны оноо
300	50	2018-2020 оны дундаж
360	40	
420	30	
480	20	
540	10	
600	0	Хамгийн сул

¹⁶ <https://rm.coe.int/1680747548>

захиргааны хэрэг) 240 байсан гэж тооцвол индексийн оноо нь 60.00 байна гэсэн үг. 2021 оны үнэлгээ нь шийдвэрлэгдээгүй хэрэг 60 хэргээр буурсан үр дүнг харуулж байгаа бөгөөд энэ нь индексийн хүрээнд 10 хувиар сайжирсныг илтгэнэ. Энэхүү аргачлалаар нийт 11 шалгуур үзүүлэлтийг тооцсон.

Аргачлал 2: Захиргааны мэдээллийг оноонд хувиргасан энэхүү аргын тухайд шалгуур үзүүлэлтийн хэмжүүрийн нэгж нь хувиар илэрхийлэгдэх Хэрэг шийдвэрлэлтийн хувь (Clearance rates)¹⁷ шалгуур үзүүлэлт хамаарч байна.

Онолын хувьд энэхүү үзүүлэлтүүдийн ихэнх нь 100 хувийн дээд утгатай байх ёстой (жишээ нь, хэрэв бүх шүүх шийдвэрлэвэл зохих бүх хэрэг, маргааныг шийдвэрлэсэн бол Хэрэг шийдвэрлэлтийн хувь 100 хувь байх ёстой). Гэсэн хэдий ч манай улсын тухайд дэлхийн бусад улсын шүүхүүдийн нэгэн адил бүх шатны шүүхүүд тайлант хугацаанд хэргийн хоцрогдол буюу үлдэгдэлтэй гардаг тул энэхүү үзүүлэлтийн дээд утгыг 100 хувиас давуулж үзэхэд хүргэж байна.

Судалгааны баг энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд 2018-2021 оны шүүхийн захиргааны мэдээллийг шалгасан. 2018-2021 оны хэрэг шийдвэрлэлтийн хувь 87-105 хувийн хязгаарт багтаж байна. Мөн 2018-2021 оны захиргааны мэдээллээс өмнөх оны

үлдэгдэл хэрэг дараа оны шийдвэрлэвэл зохих нийт хэрэг (өмнөх оны үлдэгдэл хэргийг оруулаад)-ийн хэдэн хувийг эзэлж байгааг анхан шатны шүүхийн хүрээнд авч үзэхэд эрүүгийн хэрэг 10, иргэний хэрэг 15, захиргааны хэрэг 30 орчим хувийг эзэлж байгаа бол, давж заалдах, хяналтын шатны шүүхийн хүрээнд авч үзэхэд үлдэгдэл хэргийн эзлэх хувь хамгийн дээд хувь 10 орчим хувь байна. Эдгээрийг харгалзан энэхүү шалгуур үзүүлэлтийн хувьд анхан шатны шүүхийн хүрээнд эрүүгийн хэрэг дээр 110, иргэний хэрэг дээр 115, захиргааны хэрэг дээр 130, давж заалдах, хяналтын шатны шүүхийн хүрээнд 110 хувийн бодит утгыг хамгийн сайн хувилбараар (индексийн оноогоор 100) тогтоосон. Хамгийн сул хувилбарыг (индексийн оноогоор 0) бодит утгын 0 хувь гэж тогтоосон.

Бодит утгыг индекс рүү хөрвүүлэхдээ 130 хувийн бодит утгыг үнэлгээний 2/3-т (өөрөөр хэлбэл 0-100 индексийн оноогоор 66.66) тохируулна. Өөрөөр хэлбэл, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн хэрэг шийдвэрлэлтийн хамгийн сайн хувь 130 байх боломжтой гэж үзсэн. Жишээ нь, 2021 онд захиргааны хэргийн анхан шатны шүүхийн хэрэг шийдвэрлэлтийн бодит хувь 86.66 хувь байвал индексийн оноо 66.66 гэсэн үг. Энэхүү аргачлалаар нийт 11 шалгуур үзүүлэлтийг тооцов.

Хүснэгт 6: Аргачлал 2. Захиргааны мэдээлэлд оноо өгсөн аргачлалын жишээ

Бодит утга (тоогоор)	Индексийн оноо (0-100)	Тайлбар
0	0	Хамгийн сул
21.66	16.67	
43.33	33.33	
65	50	
86.66	66.66	2021 оны оноо
108.33	83.34	
130	100	Хамгийн сайн

¹⁷ Тухайн онд шийдвэрлэсэн хэргийн тоог тухайн онд шинээр үүсгэсэн буюу хүлээж авсан хэргийн тоонд хувааж, гарсан үр дүнг 100-аар үржүүлж хувиар илэрхийлнэ.

Аргачлал 3: Шүүгчийн ажлын ачаалал дэд хэмжигдэхүүнийг үнэлэхдээ 2018 онд хийгдсэн "Шүүгчийн ажлын ачаалал тодорхойлох судалгааны тайлан"¹⁸-аар тогтоосон анхан шатны шүүхийн нэг шүүгчид ногдох эрүү, иргэн, захиргааны хэргийн хэвийн ачааллын тоо (эрүүгийн хэрэг-70, иргэний хэрэг-200, захиргааны хэрэг-42)-г үндэслэл болгов. Гэхдээ зөвхөн уг тоог энэхүү шалгуур үзүүлэлтийг үнэлэхэд шууд үндэслэл болгох нь учир дутагдалтай байсан. Тодруулбал, 2021 онд Нийслэл дэх Захиргааны

хэргийн анхан шатны шүүх 984 хэрэг шийдвэрлэсэн нь улсын хэмжээнд шийдвэрлэгдсэн нийт захиргааны хэргийн 55.8 хувьтай тэнцжээ. Иймд энэхүү захиргааны мэдээллээс индексийн оноог гаргаж авахдаа хэргийн ачааллын хэвийн тоо болон харъяа дүүрэг/аймгийн хүн амын тоог уялдуулсан.

Жишээ нь, Нийслэлийн хэмжээнд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн хэргийн ачааллыг хэрхэн тодорхойлсон талаар тайлбарлая.

Хүснэгт 7: Аргачлал 3. Захиргааны мэдээлэлд оноо өгсөн аргачлалын жишээ

№	Шүүх	Нэг шүүгчид ногдох эрүүгийн хэргийн дундаж тоо (1)	Байвал зохих ачааллаас (75) хэтэрсэн хэргийн тоо (2)	Хүн амын тоо (2021 он) (3)	Дүүргийн хүн ам (нийслэлд эзлэх хувь) (4)	Дүүргийн хэмжээнд ажлын ачаалал хэтэрсэн байдал (0 – 100) (5)	Нийслэлийн хэмжээнд ажлын ачаалал хэтэрсэн байдал (0-100) (6)
1.	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	118.7	43.7	383,892	25%	41.73	
2.	Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	105.6	30.6	144,542	9%	59.20	
3.	Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	95.9	20.9	150,548	10%	72.13	
4.	Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	78.3	3.3	236,385	15%	95.60	
5.	Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	104	29	209,524	14%	61.33	60.64
6.	Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	116.7	41.7	341,540	22%	44.40	
7.	Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	33	0	29,433	2%	100.00	
8.	Багахангай дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	17	0	4,459	0%	100.00	
9.	Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	63.7	0	38,929	3%	100.00	

Нийт хүн амын тоо: 1,539,252

¹⁸ Шүүхийн ерөнхий зөвлөл, Хөгжлийн санаачлага, бодлого судлалын төв, Шүүгчийн ажлын ачаалал тодорхойлох судалгааны тайлан (УБ: ШЕЗ, 2018)

Нийслэлийн дүүрэг бүрийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгчид ногдох хэргийн тоо (1), нэг шүүгчид ногдох хэргийн хэвийн ачааллын тоо болон дүүрэг бүрийн хүн амын тоог тодорхойлно (2).

Дүүрэг бүрийн шүүхийн нэг шүүгчид ногдох хэргийн ачаалал хэвийн хэмжээнээс хэтэрсэн хэргийн тоог (3) тогтооно.

Дүүрэг бүрийн хүн амын тоог нийслэлийн хүн амын тоотой харьцуулан хувьчилж гаргана (4).

Шүүгчийн ажлын ачааллыг индексийн оноо (5) буюу 0-100 оноонд хөрвүүлэхийн тулд Байвал зохих ачааллаас хэтэрсэн хэргийн тоог (2) Байвал зохих хэргийн тоо буюу 75-д хуваана. Гарсан үр дүнг 1-ээс хасаж 100-д үржүүлнэ.

Нийслэлийн хэмжээнд шүүгчийн ажлын ачаалал хэтэрсэн байдлыг (6) тодорхойлохдоо Дүүргийн хэмжээнд ажлын ачаалал хэтэрсэн байдлын (5) дунджийг тухайн дүүргийн нийслэлд эзлэх хүн амын хувьд жинлэн гаргана.

Дээрх гурван аргачлалын хүрээнд үнэлэгдэхгүй шалгуур үзүүлэлт нь шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал, шүүхийн шийдвэрийн биелэлт дэд хэмжигдэхүүний бүлэг шалгуур үзүүлэлтийг үнэлэх мэдээллүүд байсан. Өөрөөр хэлбэл, онол, практикийн хувьд шүүхийн шийдвэр хэвээр үлдэх, шүүхийн шийдвэр биелэгдэх хамгийн дээд туйлын утга нь 100 хувь байна. Иймд эдгээр дэд хэмжигдэхүүний хувьд 100 хувийн бодит утгыг хамгийн сайн хувилбараар (индексийн масштабаар 100) тогтоосон.

3.1 ШҮҮХИЙН ЭРХ ХЭМЖЭЭ, БИЕ ДААСАН БАЙДАЛ

3.2 ШҮҮХИЙН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ

3.3 ШҮҮХЭД ИТГЭХ ОЛОН НИЙТИЙН ИТГЭЛ

3.4 ШҮҮХИЙН ДЭД БҮТЭЦ, НӨӨЦ

3.5 ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ БА ХАРИУЦЛАГА

3.6 ШҮҮХИЙН ҮР АШИГТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3

- ШҮҮХИЙН
ИНДЕКСИЙН
ҮНДСЭН
ХЭМЖИГДЭХҮҮН

ШҮҮХИЙН ИНДЕКС

Үндсэн хэмжигдэхүүний оноо



1. ШҮҮХИЙН ЭРХ ХЭМЖЭЭ, БИЕ ДААСАН БАЙДАЛ



2. ШҮҮХИЙН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ



3. ШҮҮХЭД ИТГЭХ ОЛОН НИЙТИЙН ИТГЭЛ



4. ШҮҮХИЙН ДЭД БҮТЭЦ, НӨӨЦ




5. ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ БА ХАРИУЦЛАГА




6. ШҮҮХИЙН ҮР АШИГТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА


ОЛОН НИЙТИЙН САНАЛ
АСУУЛГЫН ДУНДАЖ



МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН САНАЛ
АСУУЛГЫН ДУНДАЖ




ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЛИЙН
ДУНДАЖ



ШҮҮХИЙН ИНДЕКС

Ерөнхий оноо



Шүүхийн индекс
2021

100 оноо

Шүүхийн индекс 2021-ийн оноо

1. ШҮҮХИЙН ЭРХ ХЭМЖЭЭ, БИЕ ДААСАН БАЙДАЛ

Шүүхийн эрх хэмжээ, бие даасан байдал: Шүүх бие даасан байх, шүүгч хараат бусаар, хөндлөнгийн аливаа зүй бус нөлөөллөөс ангид ажиллах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлын баталгаа.

Тус хэмжигдэхүүний хүрээнд шүүхээс гүйцэтгэх, хууль тогтоох байгууллагад хяналт тавих хуулийн болон бодит боломжийг төсөөллийн судалгаанд суурилан үнэллээ.

ҮНДСЭН ХЭМЖИГДЭХҮҮНИЙ ОНОО




ОНСА

дундаж

МСА

дундаж

ДЭД ХЭМЖИГДЭХҮҮНИЙ ОНОО



1. ШҮҮХИЙН ЭРХ ХЭМЖЭЭ, БИЕ ДААСАН БАЙДАЛ: ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Шалгуур үзүүлэлт		Оноо	Эх сурвалж
1	ШҮҮХИЙН ЭРХ ХЭМЖЭЭ, БИЕ ДААСАН БАЙДАЛ	 51.60	
1.1	Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх	50.52	
1.1.1	Хүн бүр Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргах, хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэх эрхээр хангагдсан байдаг.	 60.62	ОНСА 4.1
1.1.2	Шүүх хүний хөрөнгө, орлого, нийгмийн гарал үүсэл, байр суурь, улс төрийн нөлөөлөл, шашин, арьсны өнгө, хүйс, хөгжлийн бэрхшээл зэргийг үл харгалзан алагчлалгүй, шударга ханддаг.	 46.93	ОНСА 4.2
1.1.3	Шүүгчид нэг төрлийн гэмт хэрэгт өөр өөр ял оноох, ижил агуулгатай хэрэг, маргааныг өөр өөрөөр шийдвэрлэх магадлал бага байдаг.	 48.18	ОНСА 17
1.1.4	Шүүх хүний хөрөнгө, орлого, нийгмийн гарал үүсэл, байр суурь, улс төрийн нөлөөлөл, шашин, арьсны өнгө, хүйс, хөгжлийн бэрхшээл зэргийг үл харгалзан алагчлалгүй, шударга ханддаг.	 62.99	МСА 4.1
1.1.5	Шүүгчид нэг төрлийн гэмт хэрэгт өөр өөр ял оноох, ижил агуулгатай хэрэг, маргааныг өөр өөрөөр шийдвэрлэх магадлал бага байдаг.	 33.86	МСА 6
1.2	Хууль тогтоох эрх мэдэлд тавих шүүхийн хяналт	57.01	
1.2.1	Улсын Их Хурал Үндсэн хуультай илт харшилсан хууль тогтоомж баталсан гэж тооцъё. Үндсэн хуулийн цэц Улсын Их Хурлын энэхүү хууль бус үйлдлийг таслан зогсоох боломжтой.	 58.06	ОНСА 4.6
1.2.2	Улсын Их Хурал Үндсэн хуультай илт харшилсан хууль тогтоомж баталсан гэж тооцъё. Үндсэн хуулийн цэц Улсын Их Хурлын энэхүү хууль бус үйлдлийг таслан зогсоох боломжтой.	 71.29	МСА 4.2
1.2.3	Үндсэн хуулийн цэц төрийн байгууллага, улс төрчид болон аливаа хувь хүн, хуулийн этгээдийн хөндлөнгийн нөлөөнд оролгүйгээр шийдвэр гаргадаг.	 47.99	МСА 4.3
1.2.4	Үндсэн хуулийн цэц Улсын Их Хурлын шийдвэрийг хянаж, хууль бус гэж үзэх бүрэн эрхтэй.	 50.68	МСА 9
1.3	Гүйцэтгэх эрх мэдэлд тавих шүүхийн хяналт	62.68	
1.3.1	Захиргааны байгууллага хууль бус шийдвэр гаргасан ба иргэд энэхүү шийдвэрийн эсрэг шүүхэд нэхэмжлэл гаргасан гэж тооцъё. Бодит байдал дээр шүүгч энэхүү хууль бус үйлдлийг таслан зогсоох боломжтой.	 62.16	ОНСА 4.7
1.3.2	Захиргааны байгууллага хууль бус шийдвэр гаргасан ба иргэд энэхүү шийдвэрийн эсрэг шүүхэд нэхэмжлэл гаргасан гэж тооцъё. Бодит байдал дээр шүүгч энэхүү хууль бус үйлдлийг таслан зогсоох боломжтой.	 73.49	МСА 4.4
1.3.3	Шүүх эрх мэдэл гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагааг хянаж, хууль бус гэж зарлах бүрэн эрхтэй.	 52.40	МСА 14
1.4	Шүүхийн бие даасан байдал	49.75	
1.4.1	Засгийн газар, түүний харьяа байгууллагууд шүүхийн шийдвэртэй санал зөрж байсан ч шүүхийн шийдвэрийг үргэлж биелүүлдэг.	 55.51	ОНСА 4.5

Шалгуур үзүүлэлт		Оноо	Эх сурвалж
1.4.2	Шүүхийн бие даасан байдлыг хуулиар баталгаажуулсан бөгөөд үүнийг улс төрийн түвшинд бодитойгоор хүлээн зөвшөөрдөг.	 49.66	MCA 4.5
1.4.3	Засгийн газар, түүний харьяа байгууллагууд шүүхийн шийдвэртэй санал зөрж байсан ч шүүхийн шийдвэрийг үргэлж биелүүлдэг.	 48.29	MCA 4.6
1.4.4	Шүүхийн төсөв хангалттай, хүрэлцээтэй байдаг.	 45.53	MCA 4.7
1.5	Шүүгчийн хараат бус байдал	49.09	
1.5.1	Шүүгч эсхүл шүүхийн байгууллагын албан хаагчид хээл хахууль өгч ял шийтгэлгүй өнгөрөх, эсхүл хөнгөн ялаар шийтгүүлэх болон бусад байдлаар өөрт ашигтайгаар хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэх тохиолдол гардаггүй.	 39.13	ОНСА 2
1.5.2	Шүүхийн тогтолцоонд авлига нөлөөлдөггүй.	 28.11	ОНСА 3
1.5.3	Шүүгчид төрийн байгууллага, улс төрчид болон аливаа хувь хүн, хуулийн этгээдийн хөндлөнгийн зүй бус нөлөөнд автахгүйгээр хэрэг, маргааныг шийдвэрлэдэг.	 46.94	ОНСА 4.3
1.5.4	Шүүхийн тогтолцоонд авлига нөлөөлдөггүй.	 52.51	MCA 3
1.5.5	Шүүгчид төрийн байгууллага, улс төрчид болон аливаа хувь хүн, хуулийн этгээдийн хөндлөнгийн зүй бус нөлөөнд автахгүйгээр хэрэг, маргааныг шийдвэрлэдэг.	 56.64	MCA 4.8
1.5.6	Шүүгчийн хараат бус байдал, бүрэн эрхийн хугацааг хуулиар баталгаажуулсан бөгөөд практикт хэрэгждэг.	 56.45	MCA 4.9
1.5.7	Шүүгч эсхүл шүүхийн байгууллагын албан хаагчид хээл хахууль өгч ял шийтгэлгүй өнгөрөх, эсхүл хөнгөн ялаар шийтгүүлэх болон бусад байдлаар өөрт ашигтайгаар хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэх тохиолдол гардаггүй.	 63.82	MCA 8
1.6	Шүүхийн ерөнхий зөвлөл	46.53	
1.6.1	Шүүхийн ерөнхий зөвлөл Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, улс төрчид болон бусад аливаа этгээдээс хараат бусаар ажилладаг.	 46.50	MCA 4.10
1.6.2	Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүгчдийн эрх, ашгийг хамгаалах чиг үүргээ хангалттай хэрэгжүүлдэг.	 46.55	MCA 4.11
1.7	Шүүх, шүүгчийн аюулгүй байдал	45.62	
1.7.1	Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах үр дүнтэй механизм, нөөц бололцоо бүрдсэн.	 50.54	MCA 4.12
1.7.2	Шаардлагатай үед шүүгч болон түүний гэр бүлийн гишүүдийн хувийн аюулгүй байдлыг хангадаг.	 40.70	MCA 5

2. ШҮҮХИЙН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ

Шүүхийн нээлттэй, ил тод байдал: Шүүхийн шийдвэр, үйл ажиллагаа олон нийтэд хүртээмжтэй байх, мэдээлэл авах боломж бүрдсэн эсэхийг хэмжинэ.

Шалгуур үзүүлэлтийн оноо нь түлхүү олон нийтийн болон мэргэжилтнүүдийн төсөөллийн судалгаанд тулгуурлан гарлаа.

ҮНДСЭН ХЭМЖИГДЭХҮҮНИЙ ОНОО



ДЭД ХЭМЖИГДЭХҮҮНИЙ ОНОО



2. ШҮҮХИЙН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ: ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ


Шалгуур үзүүлэлт		Оноо	Эх сурвалж
2	ШҮҮХИЙН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ	 62.30	
2.1	Шүүгчийн сонгон шалгаруулалт	53.02	
2.1.1	Шүүгчийг сонгон шалгаруулах ажиллагаатай танилцах, ажиглах боломж байдаг.	 75.62	ОНСА 6.1
2.1.2	Шүүгчийг сонгон шалгаруулах ажиллагаатай танилцах, ажиглах боломж байдаг.	 30.42	МСА 10.1
2.2	Хууль тогтоомж	52.60	
2.2.1	Шүүхтэй холбоотой баталсан дүрэм, журам нээлттэй, ил тод байдаг.	 52.60	МСА 10.2
2.3	Шүүхийн тайлан, статистик	69.14	
2.3.1	Шүүхийн үйл ажиллагааны тайлан, статистик мэдээлэлтэй танилцах боломж байдаг.	 77.24	ОНСА 6.4
2.3.2	Шүүхийн үйл ажиллагааны тайлан, статистик мэдээлэлтэй танилцах боломж байдаг.	 61.03	МСА 10.3
2.4	Шүүх хуралдаан	75.32	
2.4.1	Шүүгчид сонирхсон этгээдэд нээлттэй шүүх хуралдаанд суух боломжийг олгодог.	 85.73	ОНСА 6.2
2.4.2	Шүүгчид сонирхсон этгээдэд нээлттэй шүүх хуралдаанд суух боломжийг олгодог.	 64.91	МСА 10.4
2.5	Шүүхийн шийдвэр	72.35	
2.5.1	Олон нийт шүүхийн шийдвэртэй танилцах (цаасан эсхүл цахим хэлбэрээр), шүүхийн шийдвэрийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэх боломж байдаг.	 80.96	ОНСА 6.3
2.5.2	Олон нийт шүүхийн шийдвэртэй танилцах (цаасан эсхүл цахим хэлбэрээр), шүүхийн шийдвэрийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэх боломж байдаг.	 63.74	МСА 10.6
2.6	Хэргийн материалтай танилцах	85.76	
2.6.1	Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид хэргийн материалтай бүрэн бөгөөд тухай бүр танилцах боломжоор хангагддаг.	 91.29	ОНСА 6.5
2.6.2	Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид хэргийн материалтай бүрэн бөгөөд тухай бүр танилцах боломжоор хангагддаг.	 80.22	МСА 10.5
2.7	Хэрэг, нэхэмжлэлийн хуваарилалт	58.24	
2.7.1	Хэн нэгэн өөрийн хүссэн шүүгчдээ хэрэг, маргааныг хуваарилуулж шийдвэрлүүлэх боломжгүй.	 49.95	ОНСА 10
2.7.2	Хэн нэгэн өөрийн хүссэн шүүгчдээ хэрэг, маргааныг хуваарилуулж шийдвэрлүүлэх боломжгүй.	 66.52	МСА 11
2.8	Шүүхийн төсвийн ил тод байдал	50.00	
2.8.1	Шүүхийн төсвийн зарцуулалтын тайланг тогтмол гаргаж, олон нийтэд мэдээлдэг.	 50.00	ЗМ
2.9	Хэвлэл мэдээллийн сурвалжилга	44.30	
2.9.1	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мөрдөн байцаалтын болон шүүхийн шатанд байгаа хэрэг, маргааны талаарх мэдээллийг олон нийтэд үнэн, бодитой мэдээлдэг.	 51.69	ОНСА 12
2.9.2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мөрдөн байцаалтын болон шүүхийн шатанд байгаа хэрэг, маргааны талаарх мэдээллийг олон нийтэд үнэн, бодитой мэдээлдэг.	 36.91	МСА 12

3. ШҮҮХЭД ИТГЭХ ОЛОН НИЙТИЙН ИТГЭЛ


Шүүхэд итгэх олон нийтийн итгэл: Шүүх эрх мэдэл болон шүүгчийн мэдлэг, ур чадвар, ёс зүйд итгэх олон нийтийн итгэл, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны сэтгэл ханамжийн түвшин.

Энэхүү хэмжигдэхүүний үнэлгээ нь бүхэлдээ төсөөллийн судалгааны үр дүнд үндэслэж байна. Мэргэжилтнүүдийн санал асуулгад хамрагдсан 99 шүүгчийн асуумжийн хариуг энэ хэсэгт хасаж тооцсон тул хөндлөнгийн үнэлгээ гэж үзэх боломжтой.

ҮНДСЭН ХЭМЖИГДЭХҮҮНИЙ ОНОО



ДЭД ХЭМЖИГДЭХҮҮНИЙ ОНОО



ОНСА
дундаж

МСА
дундаж

3. ШҮҮХЭД ИТГЭХ ОЛОН НИЙТИЙН ИТГЭЛ: ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Шалгуур үзүүлэлт		Оноо	Эх сурвалж
3	ШҮҮХЭД ИТГЭХ ОЛОН НИЙТИЙН ИТГЭЛ	 53.17	
3.1	Шүүхийн тогтолцоо	53.45	
3.1.1	Эрүүгийн хэрэг хуулийн дагуу, шударгаар шийдвэрлэгддэг.	 49.36	ОНСА 7.1
3.1.2	Иргэний хэрэг хуулийн дагуу, шударгаар шийдвэрлэгддэг.	 51.55	ОНСА 7.2
3.1.3	Захиргааны хэрэг хуулийн дагуу, шударгаар шийдвэрлэгддэг.	 49.49	ОНСА 7.3
3.1.4	Эрүүгийн хэрэг хуулийн дагуу, шударгаар шийдвэрлэгддэг.	 57.53	МСА 13.1*
3.1.5	Иргэний хэрэг хуулийн дагуу, шударгаар шийдвэрлэгддэг.	 55.42	МСА 13.2*
3.1.6	Захиргааны хэрэг хуулийн дагуу, шударгаар шийдвэрлэгддэг.	 57.33	МСА 13.3*
3.2	Шүүгчийн шударга байдал	57.03	
3.2.1	Анхан шатны шүүхийн шүүгчид хэрэг, маргааныг хуулийн дагуу, шударгаар шийдвэрлэдэг.	 54.98	ОНСА 8.1
3.2.2	Давж заалдах шатны шүүхийн шүүгчид хэрэг, маргааныг хуулийн дагуу, шударгаар шийдвэрлэдэг.	 57.17	ОНСА 8.2
3.2.3	Улсын дээд шүүхийн шүүгчид хэрэг, маргааныг хуулийн дагуу, шударгаар шийдвэрлэдэг.	 55.07	ОНСА 8.3
3.2.4	Анхан шатны шүүхийн шүүгчид хэрэг, маргааныг хуулийн дагуу, шударгаар шийдвэрлэдэг.	 58.02	МСА 15.1*
3.2.5	Давж заалдах шатны шүүхийн шүүгчид хэрэг, маргааныг хуулийн дагуу, шударгаар шийдвэрлэдэг.	 57.64	МСА 15.2*
3.2.6	Улсын дээд шүүхийн шүүгчид хэрэг, маргааныг хуулийн дагуу, шударгаар шийдвэрлэдэг.	 59.31	МСА 15.3*
3.3	Шүүгчийн зан суртахуун	43.83	
3.3.1	Шүүгчид ёс зүйтэй, нийгэмд үлгэрлэл болж чаддаг.	 42.30	ОНСА 9.1
3.3.2	Шүүгчид ёс зүйтэй, нийгэмд үлгэрлэл болж чаддаг.	 45.35	МСА 16.1*
3.4	Шүүгчийн мэдлэг, ур чадвар	59.63	
3.4.1	Шүүгчдийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар хангалттай.	 63.94	ОНСА 11
3.4.2	Шүүгчдийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар хангалттай.	 55.31	МСА 17*
3.5	Шүүхийн процессын сэтгэл ханамж	52.08	
3.5.1	Шүүхийн шийдвэр аль талд гарах нь хамаагүй, шүүхийн үйл ажиллагааны процесс хуулийн дагуу/зөв явагддаг.	 52.08	ОНСА 9.2
3.6	Шүүхийн шийдвэрийн үндэслэл	52.99	
3.6.1	Шүүгчид шүүхийн шийдвэрээ ойлгомжтой, үндэслэл бүхий бичдэг.	 55.61	ОНСА 9.3
3.6.2	Шүүгчид шүүхийн шийдвэрээ ойлгомжтой, үндэслэл бүхий бичдэг.	 50.36	МСА 16.2*


* Шүүхэд итгэх олон нийтийн итгэл дэд хэмжигдэхүүний МСА-д шүүгчдийн асуумжид хариулсан үнэлгээг хасаж тооцсон.

4. ШҮҮХИЙН ДЭД БҮТЭЦ, НӨӨЦ


Шүүхийн дэд бүтэц, нөөц: Хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, хууль ёсны итгэлийг хамгаалахад буюу шүүхийн үйлчилгээг хэвийн, хүртээмжтэй явуулахад шаардлагатай хүний, санхүүгийн, материаллаг нөөцийн түвшин.

Шүүхийн үйлчилгээний орчин нөхцөл, дэд бүтэц, техник, технологийн боломж, хүний нөөцийн зохион байгуулалтыг төсөөллийн судалгаанд тулгуурлан үнэллээ. Төсөөллийн судалгаагаар дамжуулан шүүх иргэд болон үйлчлүүлж буй хуульчдын нүдэнд ямар байдлаар харагдаж үнэлэгдэж байгааг харах боломжтой. Нээлттэй өгөгдлийн сангаас дэлгэрэнгүйг харж тодорхой орон нутаг, шүүхийн нөхцөл байдлыг хэрхэн үнэлснийг задлан харах боломжтой.

ҮНДСЭН ХЭМЖИГДЭХҮҮНИЙ ОНОО



ДЭД ХЭМЖИГДЭХҮҮНИЙ ОНОО



4. ШҮҮХИЙН ДЭД БҮТЭЦ, НӨӨЦ: ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ


Шалгуур үзүүлэлт		Оноо	Эх сурвалж
4	ШҮҮХИЙН ДЭД БҮТЭЦ, НӨӨЦ	 44.47	
4.1	Шүүгчийн сонгон шалгаруулалт	46.91	
4.1.1	Шүүгчийг тэдний зөвхөн мэдлэг, ур чадвар, ёс зүйд нь үндэслэн томилдог.	 47.63	ОНСА 13.1
4.1.2	Шүүгчийг тэдний зөвхөн мэдлэг, ур чадвар, ёс зүйд нь үндэслэн томилдог.	 46.19	МСА 18.1
4.2	Шүүгчийн мэдлэг, ур чадвар	49.71	
4.2.1	Шүүгчид хэрэг, маргааныг зохих ёсоор шийдвэрлэхэд шаардлагатай мэргэжлийн ур чадвар, хууль, эрх зүйн мэдлэгтэй байдаг.	 36.59	ОНСА 13.2
4.2.2	Шүүгчид хэрэг, маргааныг зохих ёсоор шийдвэрлэхэд шаардлагатай мэргэжлийн ур чадвар, хууль, эрх зүйн мэдлэгтэй байдаг.	 56.76	МСА 18.2
4.2.3	Шүүгчид жил бүр хангалттай сургалт авч, мэдлэг, мэргэшлээ дээшлүүлж чаддаг.	 55.77	МСА 16.3
4.3	Шүүгчийн цалин хөлс	60.60	
4.3.1	Шүүгчдийн цалин хөлс нь бусад орлогын эх үүсвэр ашиглахгүйгээр ажиллаж, амьдрахад нь хүрэлцээтэй, мэргэшсэн шүүгчдийг татан авч үлдэхэд хангалттай байдаг.	 71.60	ОНСА 9.4
4.3.2	Шүүгчийн цалин тохирсон.	 64.31	ОНСА 14
4.3.3	Шүүгчдийн цалин хөлс нь бусад орлогын эх үүсвэр ашиглахгүйгээр ажиллаж, амьдрахад нь хүрэлцээтэй, мэргэшсэн шүүгчдийг татан авч үлдэхэд хангалттай байдаг.	 45.90	МСА 18.3
4.4	Шүүхийн захиргааны ажилтан	44.77	
4.4.1	Одоогийн шүүхийн захиргааны туслах ажилтнуудын мэдлэг, ур чадвар хангалттай байдаг.	 42.78	МСА 18.4
4.4.2	Шүүгчийг ажил үүргээ гүйцэтгэхэд хангалттай хүний нөөцийн дэмжлэг байдаг.	 46.76	МСА 18.5
4.5	Шүүхийн барилга байгууламж	32.34	
4.5.1	Шүүхийн байр шударга ёсыг илэрхийлсэн, хүндэтгэл төрүүлэхүйц орчин, дэд бүтцээр хангагдсан байдаг.	 36.71	ОНСА 13.3
4.5.2	Шүүхүүд шаардлага хангасан байранд байрладаг бөгөөд ажиллахад хангалттай өрөө, тасалгаа, зай талбайтай байдаг.	 29.35	МСА 18.6
4.5.3	Шүүхийн байр шударга ёсыг илэрхийлсэн, хүндэтгэл төрүүлэхүйц орчин, дэд бүтцээр хангагдсан байдаг.	 30.97	МСА 18.7
4.6	Шүүхийн мэдээллийн технологи	40.54	
4.6.1	Шүүхэд хэрэгцээт мэдээллийн технологийн тоног, төхөөрөмж хангалттай байдаг.	 40.54	МСА 18.8
4.7	Эрсдэлийн удирдлагын тогтолцоо	36.43	
4.7.1	Шүүхэд ирэх хэрэг, маргааны тоонд гэнэтийн, огцом өөрчлөлт бий болбол шүүх түүнийг даван туулах хангалттай нөөц, бололцоогоор хангагдсан байдаг.	 36.43	МСА 18.9

5. ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ БА ХАРИУЦЛАГА


Шүүгчийн ёс зүй ба хариуцлага: Шүүгч хувийн ашиг сонирхлоос ангид байж, өндөр ёс зүйг чандлан сахих, шүүх бүрэн эрхээ хариуцлагатайгаар хэрэгжүүлэх, хариуцлага хүлээх чадвар.

Энэхүү хэмжигдэхүүний үнэлгээ нь Шүүхийн сахилгын хороо үйл ажиллагаа эхлээгүй, өмнөх хуулийн хүрээнд ажиллаж байсан Шүүхийн ёс зүйн хорооны гишүүдийн бүрэн эрх дуусаж, томилгоо хийгдээгүй удсан, сахилгын гомдол шийдвэрлэх ажиллагаа зогсонги байдалд орсон байсантай холбоотойгоор оноо харьцангуй доогуур гарсан болохыг тэмдэглэх нь зүйтэй.

ҮНДСЭН ХЭМЖИГДЭХҮҮНИЙ ОНОО



ДЭД ХЭМЖИГДЭХҮҮНИЙ ОНОО



5. ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ БА ХАРИУЦЛАГА: ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Шалгуур үзүүлэлт		Оноо	Эх сурвалж
5	ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ БА ХАРИУЦЛАГА	 45.17	
5.1	Шүүгчийн ажлын гүйцэтгэл	55.50	
5.1.1	Шүүгчдийн ажлын гүйцэтгэл хангалттай.	 52.15	ОНСА 5
5.1.2	Шүүгчдийн ажлын гүйцэтгэл хангалттай.	 58.84	МСА 7
5.2	Шүүгчийн хариуцлагын тогтолцоо	50.73	
5.2.1	Сахилгын зөрчил гаргасан шүүгчид хариуцлага тооцох (огцруулах, эсхүл бусад төрлийн сахилгын шийтгэл ногдуулах) магадлал өндөр.	 56.76	ОНСА 4.4
5.2.2	Шүүгчийн сахилгын зөрчлийг шалган шийдвэрлэх хараат бус, нээлттэй тогтолцоо бүрдсэн.	 41.81	МСА 18.10
5.2.3	Сахилгын зөрчил гаргасан шүүгчид хариуцлага тооцох (огцруулах, эсхүл бусад төрлийн сахилгын шийтгэл ногдуулах) магадлал өндөр.	 53.62	МСА 19
5.3	Шүүгчийн сахилгын зөрчлийн процесс	42.11	
5.3.1	Хуульд заасан тохиолдол бүрт шүүгчийн эсрэг сахилгын зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг эхлүүлдэг.	 43.69	МСА 18.11
5.3.2	Шүүгчийн сахилгын зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа хараат бус, шударгаар явагддаг.	 40.52	МСА 18.12
5.4	Сахилгын шийтгэл	39.01	
5.4.1	Сахилгын хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны үр дүнд шүүгчид тохирсон шийтгэл ногдуулдаг.	 39.01	МСА 21
5.5	Шүүгчийн ёс зүй	53.69	
5.5.1	Шүүгчид ёс зүйн хэм хэмжээг үргэлж дагаж мөрддөг.	 48.60	ОНСА 18
5.5.2	Шүүгчид ёс зүйн хэм хэмжээг үргэлж дагаж мөрддөг.	 60.09	МСА 20
5.5.3	Шүүгчид сахилгын зөрчилд орохоос урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг хэрхэн дагаж мөрдөх талаарх заавар, зөвлөмж, аргачлалаар үргэлж хангагддаг.	 52.38	МСА 22
5.6	Шүүгчтэй холбоотой гомдлын мэдээлэл	30.00	
5.6.1	Шүүгчийн эсрэг гаргасан гомдол, түүний төрөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг нийтэд бүрэн, ил тод мэдээлдэг.	 30.00	ЗМ

6. ШҮҮХИЙН ҮР АШИГТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Шүүхийн үр ашигтай үйл ажиллагаа: Шүүх хэрэг, маргааныг хугацаа алдалгүйгээр шийдвэрлэх чадвар, шүүхийн шийдвэрийн биелэлтийн түвшин.

Шүүхийн үйл ажиллагаа хүртээмжтэй чанартай байхад шаардлагатай зохион байгуулалт хийгдэж байгаа талаар захиргааны мэдээлэлд үндэслэн үнэлгээ өглөө. Цаашид энэхүү үнэлгээг гаргахад шаардлагатай мэдээллийг ШЕЗ боловсруулан гаргавал бид судалгааны энэ хэсгийг баримтат, статистик мэдээлэлд тулгуурлан харьцангуй бодитой үнэлэн гаргах боломжтой юм.

ҮНДСЭН ХЭМЖИГДЭХҮҮНИЙ ОНОО



ДЭД ХЭМЖИГДЭХҮҮНИЙ ОНОО



6. ШҮҮХИЙН ҮР АШИГТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА: ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Шалгуур үзүүлэлт		Оноо	Эх сурвалж
6	ШҮҮХИЙН ҮР АШИГТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА	 54.93	
6.1	Шийдвэрлэгдээгүй хэргийн тоо	38.92	
6.1.1	Анхан шатны шүүхийн хүрээнд шийдвэрлэгдээгүй хэргийн тоо бага байдаг.	 40.24	ЗМ
6.1.2	Давж заалдах шатны шүүхийн хүрээнд шийдвэрлэгдээгүй хэргийн тоо бага байдаг.	 32.20	ЗМ
6.1.3	Хяналтын шатны шүүхийн хүрээнд шийдвэрлэгдээгүй хэргийн тоо бага байдаг.	 44.32	ЗМ
6.2	Хэрэг шийдвэрлэлтийн хувь	89.92	
6.2.1	Анхан шатны шүүхийн хэрэг шийдвэрлэлтийн хувь өндөр байдаг.	 85.63	ЗМ
6.2.2	Давж заалдах шатны шүүхийн хэрэг шийдвэрлэлтийн хувь өндөр байдаг.	 91.55	ЗМ
6.2.3	Хяналтын шатны шүүхийн хэрэг шийдвэрлэлтийн хувь өндөр байдаг.	 92.57	ЗМ
6.3	Шүүгчийн ажлын ачаалал	68.47	
6.3.1	Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачаалал хэвийн байдаг.	 71.50	ЗМ
6.3.2	Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачаалал хэвийн байдаг.	 53.40	ЗМ
6.3.3	Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачаалал хэвийн байдаг.	 80.51	ЗМ
6.4	Шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал	48.45	
6.4.1	Анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт орсон, хүчингүй болсон хувь бага байдаг.	 43.37	ЗМ
6.4.2	Давж заалдах шатны шүүхийн магадлалд өөрчлөлт орсон, хүчингүй болсон хувь бага байдаг.	 53.53	ЗМ
6.5	Шүүхийн үр ашгийн тухай төсөөлөл	34.78	
6.5.1	Шүүх хэрэг, маргааныг боломжийн хугацаанд шийдвэрлэдэг.	 24.27	ОНСА 16
6.5.2	Шүүх хэрэг, маргааныг боломжийн хугацаанд шийдвэрлэдэг.	 45.29	МСА 2
6.6	Шүүхийн захиргааны үйлчилгээ	47.54	
6.6.1	Сүүлийн 24 сарын хугацаан дахь шүүхийн байгууллагын үйлчилгээнд сэтгэл хангалуун байна.	 47.54	ОНСА 1
6.7	Шүүхийн шийдвэрийн биелэлт	56.41	
6.7.1	Шүүхийн шийдвэр үргэлж биелэгддэг.	 53.95	ОНСА 15
6.7.2	Шүүхийн шийдвэр үргэлж биелэгддэг.	 61.71	МСА 23
6.7.3	Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлт сайн байдаг.	 58.10	ЗМ
6.7.4	Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлт сайн байдаг.	 53.00	ЗМ
6.7.5	Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлт сайн байдаг.	 55.30	ЗМ

-
- 4.1 ОЛОН НИЙТИЙН САНАЛ АСУУЛГЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ
 - 4.2 МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН САНАЛ АСУУЛГЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ
 - 4.3 ОЛОН НИЙТИЙН САНАЛ АСУУЛГА БА МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН САНАЛ АСУУЛГЫН ХАРЬЦУУЛАЛТ
 - 4.4 ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛД СУУРИЛСАН ДҮН ШИНЖИЛГЭЭ
-

4

- ШҮҮХИЙН
ИНДЕКСИЙН
ДҮН
ШИНЖИЛГЭЭ

ШҮҮХИЙН ИНДЕКСИЙН ДЭД ХЭМЖИГДЭХҮҮНИЙ ХАРЬЦУУЛАЛТ




ИНДЕКС




4.1. ОЛОН НИЙТИЙН САНАЛ АСУУЛГЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ОЛОН НИЙТИЙН САНАЛ АСУУЛГААР ХАМГИЙН ӨНДӨР ОНОО АВСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ



ОЛОН НИЙТИЙН САНАЛ АСУУЛГААР ХАМГИЙН БАГА ОНОО АВСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ



АВЛИГАТАЙ ХОЛБООТОЙ АСУУДЛААР ОЛОН НИЙТИЙН ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

28.11

1.5.2 Шүүхийн тогтолцоонд авлига нөлөөлдөггүй. (ОНСА 3)

39.13

1.5.1 Шүүгч эсхүл шүүхийн байгууллагын албан хаагчид хээл хахууль өгч ял шийтгэлгүй өнгөрөх, эсхүл хөнгөн ялаар шийтгүүлэх болон бусад байдлаар өөрт ашигтайгаар хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэх тохиолдол гардаггүй. (ОНСА 2)

48.18

1.1.3 Шүүгчид нэг төрлийн гэмт хэрэгт өөр өөр ял оноох, ижил агуулгатай хэрэг, маргааныг өөр өөрөөр шийдвэрлэх магадлал бага байдаг. (ОНСА 17)


49.95

2.7.1 Хэн нэгэн өөрийн хүссэн шүүгчдээ хэрэг, маргааныг хуваарилуулж шийдвэрлүүлэх боломжгүй. (ОНСА 10)

52.08


3.5.1 Шүүхийн шийдвэр аль талд гарах нь хамаагүй, шүүхийн үйл ажиллагааны процесс хуулийн дагуу/зөв явагддаг. (ОНСА 9.2)

СҮҮЛИЙН 24 САРЫН ХУГАЦААНД ШҮҮХ ХУРАЛДААНД ОРОЛЦСОН БОЛОН ОРОЛЦООГҮЙ ХҮМҮҮСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХАМГИЙН ТОМ ЯЛГАА




4.2 МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН САНАЛ АСУУЛГЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН САНАЛ АСУУЛГЫН ХАМГИЙН ӨНДӨР ОНОО АВСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ



МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН САНАЛ АСУУЛГЫН ХАМГИЙН БАГА ОНОО АВСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ



АВЛИГАТАЙ ХОЛБООТОЙ АСУУДЛААР МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

33.86

1.1.5 Шүүгчид нэг төрлийн гэмт хэрэгт өөр өөр ял оноох, ижил агуулгатай хэрэг, маргааныг өөр өөрөөр шийдвэрлэх магадлал бага байдаг. (МСА 6)

49.66

1.4.2 Шүүхийн бие даасан байдлыг хуулиар баталгаажуулсан бөгөөд үүнийг улс төрийн түвшинд бодитойгоор хүлээн зөвшөөрдөг. (МСА 4.5)

52.51

1.5.4 Шүүхийн тогтолцоонд авлига нөлөөлдөггүй. (МСА 3)

56.64

1.5.5 Шүүгчид төрийн байгууллага, улс төрчид болон аливаа хувь хүн, хуулийн этгээдийн хөндлөнгийн зүй бус нөлөөнд автахгүйгээр хэрэг, маргааныг шийдвэрлэдэг. (МСА 4.8)

63.82

1.5.7 Шүүгч эсхүл шүүхийн байгууллагын албан хаагчид хээл хахууль өгч ял шийтгэлгүй өнгөрөх, эсхүл хөнгөн ялаар шийтгүүлэх болон бусад байдлаар өөрт ашигтайгаар хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэх тохиолдол гардаггүй. (МСА 8)

4.3 ОЛОН НИЙТИЙН САНАЛ АСУУЛГА БА МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН САНАЛ АСУУЛГЫН ХАРЬЦУУЛАЛТ

Ижил асуудлаарх олон нийтийн төсөөлийн санал асуулгын үр дүн болон мэргэжилтнүүдийн санал асуулгын үр дүн хоёрыг харьцуулж үзэхэд олон асуулт дээр олон нийтийн ойлголт, мэргэжилтнүүдийн санал хоёрын хооронд мэдэгдэхүйц ялгаатай байгааг харж болно.

1. ШҮҮХИЙН ЭРХ ХЭМЖЭЭ, БИЕ ДААСАН БАЙДАЛ



2. ШҮҮХИЙН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ

Дэд хэмжигдэхүүн	ОНСА	МСА	Ялгаа
2.1 Шүүгчийн сонгон шалгаруулалт	75.62	30.42	45.20
2.3 Шүүхийн тайлан, статистик	77.24	61.03	16.21
2.4 Шүүх хуралдаан	85.73	64.91	20.82
2.5 Шүүхийн шийдвэр	80.96	63.74	17.22
2.6 Хэргийн материалтай танилцах	91.29	80.22	11.07
2.7 Хэрэг, нэхэмжлэлийн хуваарилалт	49.95	66.52	-16.57
2.9 Хэвлэл мэдээллийн сурвалжилга	51.69	36.91	14.78

3. ШҮҮХЭД ИТГЭХ ОЛОН НИЙТИЙН ИТГЭЛ

Дэд хэмжигдэхүүн	ОНСА	МСА	Ялгаа
3.1 Шүүхийн тогтолцоо	50.13	56.76	-6.63
3.2 Шүүгчийн шударга байдал	55.74	58.32	-2.58
3.3 Шүүгчийн зан суртахуун	42.30	45.35	-3.05
3.4 Шүүгчийн мэдлэг, ур чадвар	63.94	55.31	8.63
3.6 Шүүхийн шийдвэрийн үндэслэл	55.61	50.36	5.25

4. ШҮҮХИЙН ДЭД БҮТЭЦ, НӨӨЦ



5. ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ БА ХАРИУЦЛАГА



6. ШҮҮХИЙН ҮР АШИГТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Дэд хэмжигдэхүүн	ОНСА	МСА	Ялгаа
6.5 Шүүхийн үр ашгийн тухай төсөөлөл	24.27	45.29	-21.02
6.7 Шүүхийн шийдвэрийн биелэлт	53.95	61.71	-7.76

Тайлбар: 2.1 Шүүгчийн сонгон шалгаруулалтын ил тод байдал дээр олон нийтийн үнэлгээтэй харьцуулахад мэргэжилтнүүдийн үнэлгээ бага байх ба үнэлгээний зөрүү хамгийн өндөр буюу 45.20 байна.

Харин 6.5 Шүүхийн үр ашгийн тухай төсөөлөл дэд хэмжигдэхүүний хувьд олон нийт мэргэжилтнүүдээс харьцангуй бага үнэлгээ өгсөн ба зөрүү нь 21.02 байна.

4.4 ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛД СУУРИЛСАН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ШҮҮХИЙН ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Монгол Улсын шүүхийн 2021 оны жилийн эцсийн тайлан бүрэн эхээрээ 2022 оны 4 дүгээр сарын 04-ний өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудаст байршсан¹⁹ байх бөгөөд жил бүр ШЕЗ-өөс бүрэн

тайлан гаргаж, шүүхийн төсвийн зарцуулалтыг нийтэд мэдээлдэг байна. Гэсэн хэдий ч тайлан нийтлэх хугацаа тодорхойгүй, тогтмол гаргадаггүй зэргээс шалтгаалан энэ дэд хэмжигдэхүүнийг 50 хувиар үнэлэв.

Хүснэгт 8. “2.8.1 Шүүхийн төсвийн зарцуулалтын тайланг тогтмол гаргаж, олон нийтэд мэдээлдэг.” шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

Тайлбар	Индексийн оноо (0-100)
Тайланг тогтмол гаргаж, нийтэд мэдээлдэг /улирал бүр/	100
Тайланг гаргаж, нийтэд мэдээлдэг /жилд 2-оос доошгүй удаа/	75
Тайланг заримдаа гаргаж, нийтэд мэдээлдэг /жилд 1 удаа/	50
Тайланг гаргаж, олон нийтэд мэдээлсэн боловч бүрэн бус, эсхүл хангалттай нарийвчлан гаргаагүй	25
Тайлан гаргадаггүй эсвэл олон нийтэд мэдээлдэггүй	0

ШҮҮГЧТЭЙ ХОЛБООТОЙ ГОМДЛЫН МЭДЭЭЛЭЛ

Энэ дэд хэмжигдэхүүний хүрээнд шүүгчийн эсрэг гаргасан гомдол, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг нийтэд нээлттэй мэдээлж буй эсэхийг хянаж үзсэн. Тодруулбал, шүүгчийн ёс зүйн зөрчлийн талаар гаргасан өргөдөл, гомдлын бүртгэл, хуваарилалт, Шүүхийн ёс зүйн хорооны хуралдааны

тов, хуралдааны тойм, Шүүхийн ёс зүйн хорооны шийдвэр, Шүүхийн Ёс зүйн хорооны үйл ажиллагааны буюу хэргийн тайлан, статистик мэдээллийг нийтэд нээлттэй мэдээлж байсан эсэхийг дараах хэмжүүрээр үнэлэв.

Хүснэгт 9. “5.6.1 Шүүгчийн эсрэг гаргасан гомдол, түүний төрөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг нийтэд бүрэн, ил тод мэдээлдэг.” шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

Тайлбар	Индексийн оноо (0-100)
Мэдээллийг бүрэн, ил тод тогтмол нийтэд мэдээлдэг	100
Мэдээллийг бүрэн, ил тодоор нийтэд мэдээлдэг	75
Мэдээллийг бүрэн бус байдлаар нийтэд мэдээлдэг	50
Мэдээллийг нийтэд маш ховор мэдээлсэн, эсвэл олж авахад төвөгтэй	25
Мэдээллийг нийтэд ил тод зарлаагүй	0

¹⁹ “Монгол Улсын шүүхийн тайлан 2021 хэвлэгдлээ”, 2022.04.04., http://www.judcouncil.mn/site/news_full/11991
[Сүүлд үзсэн: 2022.04.11]

2020 онд Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүнд нэр дэвшүүлэх, томилох ажиллагаа удааширч бүрэлдэхүүн бүрдээгүйн улмаас шүүгчийн талаар гаргасан гомдол, маргааныг шийдвэрлэж чадаагүй байдаг. Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаас тус хорооны даргад нэр дэвшүүлсэн Т.Мөнх-Эрдэнийг Монгол Улсын Ерөнхийлөгч 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 147 дугаар зарлигаар томилсноор бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн байна.

2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр батлагдсан Монгол Улсын шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 6 дугаар зүйлд "Шүүхийн сахилгын хороо байгуулагдах хүртэлх хугацаанд шүүгчийн ёс зүйн зөрчлийн талаар гарсан гомдол, маргааныг Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө уг харилцааг зохицуулж байсан хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ" гэж заасан тул Шүүхийн ёс зүйн хороо чиг үүргээ үргэлжлүүлэн хэрэгжүүлж ажилласан.

2021 оны Шүүхийн Ёс зүйн хорооны гомдол хэлэлцэх хуралдаан болон нийт гишүүдийн хуралдааныг тус бүр 9 удаа товлон зарлаж, хуралдсан байна.²⁰ Гэвч Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны тов, тойм зэргийг тухай бүр нийтэд мэдээлээгүй. Харин Шүүхийн Ёс зүйн хорооны 2021 оны 1 дүгээр үйл ажиллагааны талаарх мэдээллийг 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудсанд байршуулсан²¹ ба түүнээс хойш үйл ажиллагааны талаар мэдээлээгүй. Улмаар Монгол Улсын шүүхийн 2021 оны жилийн эцсийн тайлан²² -аар Шүүхийн

Ёс зүйн хороонд ирүүлсэн өргөдөл, гомдол, түүний шийдвэрлэлтийн талаарх статистик мэдээллийг оруулсан.

2021 онд гарсан Шүүхийн Ёс зүйн хорооны шийдвэрийг бүрэн эхээр нь үзэж, танилцах боломжтой байдлаар хэвлэмэл болон цахим хэлбэрээр нийтэд хүргээгүй. Гэсэн хэдий ч 2017-2019 онд гарсан Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал, Улсын Дээд шүүхийн тогтоолыг хэвлэж, нийтийн хүртээл болгосон, 2020 онд Шүүхийн ёс зүйн хороо ажиллаагүй зэрэг нөхцөл байдлыг харгалзан зохих оноог өгөв.

Шүүхийн Ёс зүйн хороонд ирж байгаа өргөдөл, гомдлын бүртгэл, хуваарилалтын талаар мэдээллийг нийтэд хүргээгүй. Харин Монгол Улсын шүүхийн тайлан (2021)-д "Азийн сан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Мэдээллийн технологийн хэлтэстэй хамтран Шүүхийн Ёс зүйн хороонд ирсэн гомдлыг бүртгэх, хяналт шалгалтын явцыг бүртгэлээр хянах, шүүгч өөрийн талаар гаргасан гомдолтой танилцах, хариу тайлбар гаргах нөхцөлийг бүрдүүлсэн "Бүртгэл, хяналтын систем"-ийг нэвтрүүлж, ашиглаж эхэлсэн нь дотоод үйл ажиллагааг хянах, шүүгчийн ёс зүйн зөрчлийн талаарх өргөдөл, гомдол, түүний шийдвэрлэлтийн талаарх статистик гаргах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах ач холбогдолтой болсон²³ талаар дурджээ.

Дээр дурдсан мэдээлэлд үндэслэн "Шүүгчтэй холбоотой гомдлын талаарх мэдээлэл" дэд хэмжигдэхүүний индексийн оноог дараах байдлаар дүгнэж гаргав.

²⁰ Монгол Улсын шүүхийн тайлан (2021 он). УБ., 2022, 102 дахь тал

²¹ https://www.judcouncil.mn/site/news_full/11190#

²² Монгол Улсын Шүүхийн тайлан (2021 он). УБ., 2022, 100-104 дэх тал.

²³ Монгол Улсын шүүхийн тайлан (2021 он). УБ., 2022, 99 дэх тал

Хүснэгт 10. “5.6.1 Шүүгчийн эсрэг гаргасан гомдол, түүний төрөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг нийтэд бүрэн, ил тод мэдээлдэг.” шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

Шалгуур үзүүлэлт	Индексийн оноо (0-100)
Өргөдөл, гомдлын бүртгэл, хуваарилалтын мэдээлэл	0
Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны товын талаарх мэдээлэл	0
Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны тоймын талаарх мэдээлэл	0
Шүүхийн Ёс зүйн хорооны шийдвэрийг бүрэн эхээр нь үзэж боломж	75
Шүүхийн Ёс зүйн хорооны үйл ажиллагааны тайлан, статистикийг гаргасан байдал	75
Дундаж	30

ШИЙДВЭРЛЭГДЭЭГҮЙ ХЭРГИЙН ТОО БА ХЭРЭГ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ХУВЬ

Хүснэгт 11-д Шүүхийн үр ашигтай үйл ажиллагаа үндсэн хэмжигдэхүүний дэд хэмжигдэхүүн болох шийдвэрлэгдээгүй хэргийн тоо ба хэрэг шийдвэрлэлтийн хувийн шалгуур үзүүлэлт, түүний бодит утга ба индексийн оноог харуулав. Эдгээр дэд хэмжигдэхүүний үнэлгээг 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний хооронд эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагааг хамруулан анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн хүрээнд гаргасан. Ингэхдээ тайлангийн 2.4 дэх хэсэгт тайлбарласан члан 2018-2020 оны захиргааны мэдээллийг шалгуур үзүүлэлтийн бодит утгыг индексийн оноонд хөрвүүлэхэд ашигласан. Шалгуур үзүүлэлт тус бүрийн дэд хэмжигдэхүүнд эзлэх жинг тэнцүү (шүүхийн шат тус бүр 33.33% байна) байхаар тогтоов.

Хүснэгт 11. “6.1 Шийдвэрлэгдээгүй хэргийн тоо” дэд хэмжигдэхүүний үнэлгээ

№	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн бодит утга				Бодит утгыг индексрүү хөрвүүлсэн (0-100 оноо)			Индексийн оноо (0-100)	
		2018 он	2019 он	2020 он	2021 он	0 оноо	50 оноо	100 оноо		
6.1.1.	Анхан шатны шүүх	Эрүүийн хэрэг	802	887	1,139	1,156	1,885	943	0	38.67
		Иргэний хэрэг	5,966	7,107	7,812	8,947	13,923	6,962	0	35.74
		Захиргааны хэрэг	746	717	775	810	1492	746	0	54.33
		Зөрчлийн хэрэг	25	27	37	40	59	30	0	32.2
6.1.2.	Давж заалдах шатны шүүх	Эрүүийн хэрэг	86	104	169	138	239	120	0	42.26
		Иргэний хэрэг	135	148	294	183	385	192	0	52.22
		Захиргааны хэрэг	84	77	95	111	171	85	0	34.32
		Зөрчлийн хэрэг	6	11	9	19	17	9	0	0
6.1.3.	Хяналтын шатны шүүх	Эрүүийн хэрэг	10	44	84	40	92	46	0	56.04
		Иргэний хэрэг	89	38	16	119	95	48	0	0
		Захиргааны хэрэг	22	41	36	15	66	33	0	76.92
38.92										

Хүснэгт 12. "6.2 Хэрэг шийдвэрлэлтийн хувь" дэд хэмжигдэхүүний үнэлгээ

№	Шалгуур үзүүлэлт		Шалгуур үзүүлэлтийн бодит утга				Бодит утгыг индекс рүү хөрвүүлсэн (0-100 оноо)			Индексийн оноо (0-100)
			2018 он	2019 он	2020 он	2021 он	0 оноо	50 оноо	100 оноо	
6.2.1.	Анхан шатны шүүх	Эрүүийн хэрэг	99.26	99.41	98.29	99.87	0%		110%	90.79
		Иргэний хэрэг	101.46	97.44	98.70	97.56	0%		115%	84.84
		Захиргааны хэрэг	87.88	101.69	95.55	98.77	0%		130%	75.98
		Зөрчлийн хэрэг	99.87	99.99	99.95	99.99	0%		110%	90.90
6.2.2.	Давж заалдах шатны шүүх	Эрүүийн хэрэг	101.15	99.25	97.70	101.45	0%		110%	92.22
		Иргэний хэрэг	104.02	99.61	96.04	104.30	0%		110%	94.82
		Захиргааны хэрэг	99.93	100.42	98.82	98.98	0%		110%	89.98
		Зөрчлийн хэрэг	98.40	98.70	100.48	98.11	0%		110%	89.19
6.2.3.	Хяналтын шатны шүүх	Эрүүийн хэрэг	102.90	96.46	96.59	105.09	0%		110%	95.54
		Иргэний хэрэг	103.65	103.98	102.03	96.27	0%		110%	87.52
		Захиргааны хэрэг	99.17	97.09	100.66	104.13	0%		110%	94.66
89.92										

ШҮҮГЧИЙН АЖЛЫН АЧААЛАЛ

Шүүгчийн ажлын ачаалал дэд хэмжигдэхүүнийг “Шүүгчийн ажлын ачаалал тодорхойлох судалгааны тайлан”²⁴ -д дурдсан нэг шүүгчид ногдох хэргийн хэвийн ачааллын тоо (эрүүгийн хэрэг-75, иргэний хэрэг-200, захиргааны хэрэг-42)-г үндэслэл болгон 2021 онд нэг шүүгчид ногдох хэргийг тоог тухайн шүүхийн харьяаллын нутаг дэвсгэрийн хүн амын

тоотой уялдуулж тооцов. Ийнхүү индексийн үнэлгээг гаргахад эрүүгийн, иргэний, захиргааны хэргийн анхан шатны хэрэг, маргааныг шийдвэрлэсэн шүүгчдийн ажлын ачааллын индексийн оноо тус бүр харгалзан 71.50, 53.40, 80.51 буюу дунджаар 68.47 байна. Шүүгчийн ажлын ачааллын дэлгэрэнгүй өгөгдлийг Хавсралт 4-өөс харна уу.

Хүснэгт 13. “6.3 Шүүгчийн ажлын ачаалал” дэд хэмжигдэхүүний үнэлгээ

№	Шалгуур үзүүлэлт	Хамрах хүрээ	Хүн ам	Хүн амын эзлэх хувь	Ажлын ачааллын нормализаци хийсэн утга
6.3.1	Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч	Нийслэл	1,539,252	47%	60.64%
		21 аймаг	1,770,767	53%	80.94%
		Нийт хүн ам	3,310,019		
Индексийн оноо					71.50
6.3.2	Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч	Нийслэл	1,539,252	47%	31.88%
		21 аймаг	1,770,767	53%	72.54%
		Нийт хүн ам	3,310,019		
Индексийн оноо					53.40
6.3.3	Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч	Нийслэл	1,539,252	58.10%	
		21 аймаг	1,770,767	100%	
		Нийт хүн ам	3,310,019		
Индексийн оноо					80.51
Дундаж оноо					68.47

²⁴Шүүхийн ерөнхий зөвлөл, Хөгжлийн санаачлага, бодлого судлалын төв, Шүүгчийн ажлын ачаалал тодорхойлох судалгааны тайлан (УБ: ШЕЗ, 2018)

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

“6.4 Шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал” дэд хэмжигдэхүүний үнэлгээг гаргахдаа бодит утгыг шууд индексийн оноонд шилжүүлж тооцов. Жишээ нь, шүүхийн шийдвэрт өөрчлөлт орсон, хүчингүй болсон хувь 51%, харин хэвээр үлдсэн хувьд 49% байвал энэ нь индексийн оноогоор шууд 49.00 болно. 2021 оны Монгол Улсын шүүхийн тайлангаас үзэхэд шүүхийн

шийдвэрийн тогтвортой байдал нийт хэргийн хувьд анхан шатны шүүхийн шийдвэрийн 43.36%, давж заалдах шатны шүүхийн магадлалын 53.53% нь хэвээр үлдэж, индексийн оноо 48.45 байна. 2018-2020 оны шүүхийн шийдвэр, магадлын хэвээр үлдсэн хувь 2021 оны индексийн оноонд нөлөөлөөгүй ч харьцуулж харуулах зорилгоор оруулав.

Хүснэгт 14. “6.4 Шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал” дэд хэмжигдэхүүний үнэлгээ

№	Шалгуур үзүүлэлт	Хэргийн төрөл	Шийдвэр, магадлал хэвээр үлдсэн хувь			
			2018 он	2019 он	2020 он	2021 он
6.4.1	Анхан шатны шүүхийн шийдвэр	Эрүүгийн хэрэг	40.1	41.5	41	43.1
		Иргэний хэрэг	43	44.5	45.1	43.9
		Захиргааны хэрэг	37.8	39	41.1	43.1
Индексийн оноо						43.37
6.4.2	Давж заалдах шатны шүүхийн магадлал	Эрүүгийн хэрэг	46.7	42.4	48.5	42.5
		Иргэний хэрэг	56.7	63.1	56.6	58.1
		Захиргааны хэрэг	66	66	68.4	60
Индексийн оноо						53.53
Дундаж оноо						48.45

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ

Шүүхийн шийдвэрийн биелэлт дэд хэмжигдэхүүний захиргааны мэдээллээр үнэлэгдэх шалгуур үзүүлэлтийн индексийн оноог 2021 онд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад албадан

гүйцэтгүүлэхээр ирүүлсэн эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлийн хувиар тооцож гаргав.

Хүснэгт 15. “6.7.3-6.7.5 Эрүүгийн, иргэний, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлт сайн байдаг.” шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

Хэргийн төрөл	Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн	Үлдэгдэл	Гүйцэтгэлийн хувь	Индексийн оноо (0-100)
Эрүүгийн хэрэг	7,358	4,279	3,079	58.1%	58.10
Иргэний хэрэг	26,135	13,868	12,267	53%	53.00
Захиргааны хэрэг	456	252	204	55.3%	55.30

ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ 1. ШҮҮХИЙН ИНДЕКСИЙН ҮР ДҮНГИЙН НЭГДСЭН ХҮСНЭГТ

№	Шалгуур үзүүлэлт	Оноо	Эх сурвалж	Жин
ШҮҮХИЙН ИНДЕКС		51.94		
1	Шүүхийн эрх хэмжээ, бие даасан байдал	51.60		16.67%
1.1	Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх	50.52		14.29%
1.1.1	Хүн бүр Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргах, хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэх эрхээр хангагдсан байдаг.	 60.62	ОНСА 4.1	20.00%
1.1.2	Шүүх хүний хөрөнгө, орлого, нийгмийн гарал үүсэл, байр суурь, улс төрийн нөлөөлөл, шашин, арьсны өнгө, хүйс, хөгжлийн бэрхшээл зэргийг үл харгалзан алагчлалгүй, шударга ханддаг.	 46.93	ОНСА 4.2	20.00%
1.1.3	Шүүгчид нэг төрлийн гэмт хэрэгт өөр өөр ял оноох, ижил агуулгатай хэрэг, маргааныг өөр өөрөөр шийдвэрлэх магадлал бага байдаг.	 48.18	ОНСА 17	20.00%
1.1.4	Шүүх хүний хөрөнгө, орлого, нийгмийн гарал үүсэл, байр суурь, улс төрийн нөлөөлөл, шашин, арьсны өнгө, хүйс, хөгжлийн бэрхшээл зэргийг үл харгалзан алагчлалгүй, шударга ханддаг.	 62.99	МСА 4.1	20.00%
1.1.5	Шүүгчид нэг төрлийн гэмт хэрэгт өөр өөр ял оноох, ижил агуулгатай хэрэг, маргааныг өөр өөрөөр шийдвэрлэх магадлал бага байдаг.	 33.86	МСА 6	20.00%
1.2	Хууль тогтоох эрх мэдэлд тавих шүүхийн хяналт	57.01		14.29%
1.2.1	Улсын Их Хурал Үндсэн хуультай илт харшилсан хууль тогтоомж баталсан гэж тооцё. Үндсэн хуулийн цэц Улсын Их Хурлын энэхүү хууль бус үйлдлийг таслан зогсоох боломжтой.	 58.06	ОНСА 4.6	25.00%
1.2.2	Улсын Их Хурал Үндсэн хуультай илт харшилсан хууль тогтоомж баталсан гэж тооцё. Үндсэн хуулийн цэц Улсын Их Хурлын энэхүү хууль бус үйлдлийг таслан зогсоох боломжтой.	 71.29	МСА 4.2	25.00%
1.2.3	Үндсэн хуулийн цэц төрийн байгууллага, улс төрчид болон аливаа хувь хүн, хуулийн этгээдийн хөндлөнгийн нөлөөнд оролгүйгээр шийдвэр гаргадаг.	 47.99	МСА 4.3	25.00%
1.2.4	Үндсэн хуулийн цэц Улсын Их Хурлын шийдвэрийг хянаж, хууль бус гэж үзэх бүрэн эрхтэй.	 50.68	МСА 9	25.00%
1.3	Гүйцэтгэх эрх мэдэлд тавих шүүхийн хяналт	62.68		14.29%
1.3.1	Захиргааны байгууллага хууль бус шийдвэр гаргасан ба иргэд энэхүү шийдвэрийн эсрэг шүүхэд нэхэмжлэл гаргасан гэж тооцё. Бодит байдал дээр шүүгч энэхүү хууль бус үйлдлийг таслан зогсоох боломжтой.	 62.16	ОНСА 4.7	33.33%

1.3.2	Захиргааны байгууллага хууль бус шийдвэр гаргасан ба иргэд энэхүү шийдвэрийн эсрэг шүүхэд нэхэмжлэл гаргасан гэж тооцъё. Бодит байдал дээр шүүгч энэхүү хууль бус үйлдлийг таслан зогсоох боломжтой.		73.49	MCA 4.4	33.33%
1.3.3	Шүүх эрх мэдэл гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагааг хянаж, хууль бус гэж зарлах бүрэн эрхтэй.		52.40	MCA 14	33.33%
1.4	Шүүхийн бие даасан байдал		49.75		14.29%
1.4.1	Засгийн газар, түүний харьяа байгууллагууд шүүхийн шийдвэртэй санал зөрж байсан ч шүүхийн шийдвэрийг үргэлж биелүүлдэг.		55.51	ОНСА 4.5	25.00%
1.4.2	Шүүхийн бие даасан байдлыг хуулиар баталгаажуулсан бөгөөд үүнийг улс төрийн түвшинд бодитойгоор хүлээн зөвшөөрдөг.		49.66	MCA 4.5	25.00%
1.4.3	Засгийн газар, түүний харьяа байгууллагууд шүүхийн шийдвэртэй санал зөрж байсан ч шүүхийн шийдвэрийг үргэлж биелүүлдэг.		48.29	MCA 4.6	25.00%
1.4.4	Шүүхийн төсөв хангалттай, хүрэлцээтэй байдаг.		45.53	MCA 4.7	25.00%
1.5	Шүүгчийн хараат бус байдал		49.09		14.29%
1.5.1	Шүүгч эсхүл шүүхийн байгууллагын албан хаагчид хээл хахууль өгч ял шийтгэлгүй өнгөрөх, эсхүл хөнгөн ялаар шийтгүүлэх болон бусад байдлаар өөрт ашигтайгаар хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэх тохиолдол гардаггүй.		39.13	ОНСА 2	14.29%
1.5.2	Шүүхийн тогтолцоонд авлига нөлөөлдөггүй.		28.11	ОНСА 3	14.29%
1.5.3	Шүүгчид төрийн байгууллага, улс төрчид болон аливаа хувь хүн, хуулийн этгээдийн хөндлөнгийн зүй бус нөлөөнд автахгүйгээр хэрэг, маргааныг шийдвэрлэдэг.		46.94	ОНСА 4.3	14.29%
1.5.4	Шүүхийн тогтолцоонд авлига нөлөөлдөггүй.		52.51	MCA 3	14.29%
1.5.5	Шүүгчид төрийн байгууллага, улс төрчид болон аливаа хувь хүн, хуулийн этгээдийн хөндлөнгийн зүй бус нөлөөнд автахгүйгээр хэрэг, маргааныг шийдвэрлэдэг.		56.64	MCA 4.8	14.29%
1.5.6	Шүүгчийн хараат бус байдал, бүрэн эрхийн хугацааг хуулиар баталгаажуулсан бөгөөд практикт хэрэгждэг.		56.45	MCA 4.9	14.29%
1.5.7	Шүүгч эсхүл шүүхийн байгууллагын албан хаагчид хээл хахууль өгч ял шийтгэлгүй өнгөрөх, эсхүл хөнгөн ялаар шийтгүүлэх болон бусад байдлаар өөрт ашигтайгаар хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэх тохиолдол гардаггүй.		63.82	MCA 8	14.29%
1.6	Шүүхийн ерөнхий зөвлөл		46.53		14.29%
1.6.1	Шүүхийн ерөнхий зөвлөл Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, улс төрчид болон бусад аливаа этгээдээс хараат бусаар ажилладаг.		46.50	MCA 4.10	50.00%
1.6.2	Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүгчийн эрх, ашгийг хамгаалах чиг үүргээ хангалттай хэрэгжүүлдэг.		46.55	MCA 4.11	50.00%
1.7	Шүүх, шүүгчийн аюулгүй байдал		45.62		14.29%

1.7.1	Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах үр дүнтэй механизм, нөөц бололцоо бүрдсэн.		50.54	MCA 4.12	50.00%
1.7.2	Шаардлагатай үед шүүгч болон түүний гэр бүлийн гишүүдийн хувийн аюулгүй байдлыг хангадаг.		40.70	MCA 5	50.00%
2	Шүүхийн нээлттэй, ил тод байдал		62.30		16.67%
2.1	Шүүгчийн сонгон шалгаруулалт		53.02		11.11%
2.1.1	Шүүгчийг сонгон шалгаруулах ажиллагаатай танилцах, ажиглах боломж байдаг.		75.62	ОНСА 6.1	50.00%
2.1.2	Шүүгчийг сонгон шалгаруулах ажиллагаатай танилцах, ажиглах боломж байдаг.		30.42	MCA 10.1	50.00%
2.2	Хууль тогтоомж		52.60		11.11%
2.2.1	Шүүхтэй холбоотой баталсан дүрэм, журам нээлттэй, ил тод байдаг.		52.60	MCA 10.2	100.00%
2.3	Шүүхийн тайлан, статистик		69.14		11.11%
2.3.1	Шүүхийн үйл ажиллагааны тайлан, статистик мэдээлэлтэй танилцах боломж байдаг.		77.24	ОНСА 6.4	50.00%
2.3.2	Шүүхийн үйл ажиллагааны тайлан, статистик мэдээлэлтэй танилцах боломж байдаг.		61.03	MCA 10.3	50.00%
2.4	Шүүх хуралдаан		75.32		11.11%
2.4.1	Шүүгчид сонирхсон этгээдэд нээлттэй шүүх хуралдаанд суух боломжийг олгодог.		85.73	ОНСА 6.2	50.00%
2.4.2	Шүүгчид сонирхсон этгээдэд нээлттэй шүүх хуралдаанд суух боломжийг олгодог.		64.91	MCA 10.4	50.00%
2.5	Шүүхийн шийдвэр		72.35		11.11%
2.5.1	Олон нийт шүүхийн шийдвэртэй танилцах (цаасан эсхүл цахим хэлбэрээр), шүүхийн шийдвэрийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэх боломж байдаг.		80.96	ОНСА 6.3	50.00%
2.5.2	Олон нийт шүүхийн шийдвэртэй танилцах (цаасан эсхүл цахим хэлбэрээр), шүүхийн шийдвэрийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэх боломж байдаг.		63.74	MCA 10.6	50.00%
2.6	Хэргийн материалтай танилцах		85.76		11.11%
2.6.1	Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид хэргийн материалтай бүрэн бөгөөд тухай бүр танилцах боломжоор хангагддаг.		91.29	ОНСА 6.5	50.00%
2.6.2	Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид хэргийн материалтай бүрэн бөгөөд тухай бүр танилцах боломжоор хангагддаг.		80.22	MCA 10.5	50.00%
2.7	Хэрэг, нэхэмжлэлийн хуваарилалт		58.24		11.11%
2.7.1	Хэн нэгэн өөрийн хүссэн шүүгчдээ хэрэг, маргааныг хуваарилуулж шийдвэрлүүлэх боломжгүй.		49.95	ОНСА 10	50.00%

